



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 28 (601)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай*
- *Хохирогчид нөхөх олговор олгох тухай*
- *Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2009 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын хэсгэл

2009 оны долдугаар сарын 30 № 28 (601)

Улаанбаатар хот

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

381.	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	648
382.	Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай	649
383.	Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	659
384.	Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	659
385.	Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	660
386.	Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	662
387.	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай	662
388.	Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай	662
389.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	663
390.	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	663
391.	Хохирогчид нөхөх олговор олгох тухай	663
392.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	664
393.	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	665
394.	Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	665
395.	Нийгмийн даатгалын тухай хуулийн зарим заалтыг дагаж мөрдөх журмын тухай	665
396.	Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	665
397.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	666
398.	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай	666
399.	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай	666
400.	Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай	667
401.	Иргэний хуульд аарчлөлт оруулах тухай	668
402.	Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	668
403.	Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай	669
404.	Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	670
405.	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай	670

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

406.	Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай	Дугаар 54	670
407.	Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 55	670
408.	Улсын Их Хурлын 2009 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх		

	асуудлын тухай	Дугаар 56	671
409.	Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай	Дугаар 57	673
410.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 58	673
411.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 24 дүгээр тойрогт нөхөн сонгууль товлон зарлах тухай	Дугаар 59	673
412.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 24 дүгээр тойрогт явуулах нөхөн сонгуулийн зардлын хэмжээг тогтоох тухай	Дугаар 60	674
413.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн алба хашиж байсан Н.Энхбаярын хангамжийн тухай	Дугаар 61	674

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

414.	Зарим албан тушаалын цалингийн жишгийг тогтоох тухай	Дугаар 76	674
415.	Зарим агентлагийн байршлыг тогтоох тухай	Дугаар 77	675
416.	Нэрэмжит болгох тухай	Дугаар 78	675

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

417.	Улсын үлэг явуулах тухай	Дугаар 37	675
------	--------------------------	-----------	-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь зүйл, заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.4.25, 5.4.26 дахь заалт:

“5.4.25. Зэвсэгт хүчний хөгжлийн сан;
5.4.26. Орон сууц хөгжүүлэх сан.”

2/6 дугаар зүйлийн 6.4.13, 6.4.14 дэх заалт:

“6.4.13. Зэвсэгт хүчний хөгжлийн сан;
6.4.14. Орон сууц хөгжүүлэх сан.”

3/21^д дугаар зүйл:

“21^д дугаар зүйл. Орон сууц хөгжүүлэх

сан

21^д.1. Орон сууц хөгжүүлэх сангийн хөрөнгө нь энэ хуулийн 7.1-д зааснаас гадна дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

21^д.1.1. зээлийн үйл ажиллагаанаас олсон орлого.

21^д.2. Төсвийн ерөнхийлөн захирагч нь Орон сууц хөгжүүлэх санд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг төлөвлөхдөө тухайн жилд Засгийн газраас орон сууцны талаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлыг харгалзан үзнэ.

21^д.3. Орон сууц хөгжүүлэх сангийн хөрөнгийг дараахь зориулалтаар зарцуулна:

21^д.3.1. орон сууц, түүний дэд бүтцийг шинэчлэх, сайжруулах, шинээр барих;

21^д.3.2. энэ хуулийн 21^д.3.1-д заасан зориулалтаар иргэн, хуулийн этгээдэд зээл олгох.”

4/25^д дүгээр зүйл:

“25^д дүгээр зүйл. Зэвсэгт хүчний хөгжлийн сан

25^д.1. Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгө нь энэ хуулийн 7.1-д зааснаас гадна дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

25^д.1.1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах ажиллагаанд цэрэг, цагдаагийн албан хаагчийг оролцуулсны нөхөн төлбөрийн Засгийн газраас тогтоосон зохих хэсэг;

25^д.1.2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд Монгол Улсын зэвсэгт хүчнээс ашиглуулж байгаа үндсэн болон туслах зэвсэглэл, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, материал хэрэгслийн нөхөн төлбөр;

25^д.1.3. зэвсэглэлээс хасагдаж акт тавигдсан зарим төрлийн техникийг худалдаж борлуулсны орлого;

25^д.1.4. улсын хэмжээний бүтээн байгуулалтад цэргийн анги, салбар, нэгжийг оролцуулснаас олсон ашиг;

25^д.1.5. Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагааны сургалт, бэлтгэлийн нөхөн төлбөр.

25^д.2. Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгийг дараахь зориулалтаар зарцуулна:

25^д.2.1. зэвсэгт хүчнийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцох чадварийг нэмэгдүүлэх;

25^д.2.2. террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох, нийтийг хамарсан байгалийн гамшиг, технологийн осол аюулын үед, бусад олон талт үүрэг гүйцэтгэхэд хүн, байгаль орны аюулгүй байдлыг хангах, орон нутгийн хамгаалалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний сургалт болон бэлтгэлийг хангуулах;

25^д.2.3. зэвсэгт хүчний зэвсэглэл, техникийг сэргээн сайжруулах, шинэчлэх, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх;

25^д.2.4. олон улсын цэргийн ажиллагаанд оролцохтой холбогдсон бусад үйл ажиллагааг санхүүжүүлэх;



25¹.2.5. олон улсын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаа, хүмүүнлэгийн сургалтыг Монгол Улсад зохион байгуулах;

25¹.2.6. батлан хамгаалах салбарт ажиллаж байгаа офицер, ахлагч, ажилчин, албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах;

25¹.2.7. олон улсын гэрээний заалтын дагуу зориулалт зааж олгосон хандив, тусламжаас бусад орлогын 70-аас доошгүй хувийг

энэ хуулийн 25¹.2.1-25¹.2.5-д заасан зориулалтаар.¹

2 дугаар зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсгийн "5.4.19" гэсний дараа "5.4.26" гэж, 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтын "5.4.22" гэсний дараа "5.4.25, 5.4.26" гэж тус тус нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН БАРЬЦААНЫ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг барьцаалах, үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа /ипотека/-ны гэрээ байгуулах, үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль тогтоомж

2.1. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль², Иргэний хууль², энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хуулиар нарийвчлан зохицуулаагүй бол Иргэний хуулийн ерөнхий журам үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийн барьцаа /цаашид "барьцаа" гэх/-ны гэрээнд үйлчилнэ.

3.2. Хуульд заасан үндэслэлээр барьцааны харилцаа үүссэн бөгөөд өөр хуулиар тухайн харилцааг тусгайлан зохицуулаагүй бол Иргэний хууль болон энэ хуульд заасан журам үйлчилнэ.

4 дүгээр зүйл. Барьцааны талууд

4.1. Барьцаалагч нь өөрийн шаардлагыг тэргүүн ээлжинд хангуулахаар барьцаалуулагчийн үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг барьцаалсан иргэн, хуулийн этгээд байна.

4.2. Барьцаалуулагч нь гэрээний үүргийг биелүүлэх баталгаа болгон үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг барьцаалуулсан иргэн, хуулийн этгээд байна.

4.3. Барьцаалуулагч нь үүрэг гүйцэтгэгч, эсхүл гуравдагч этгээд байж болно.

4.4. Үүрэг гүйцэтгүүлэгч, үүрэг гүйцэтгэгч нь хуулийн этгээд бол барьцаагаар хангагдах үүргийг хуульд заасан журмын дагуу нягтлан бодох

бүртгэлд тусгана.

5 дугаар зүйл. Барьцааны эрх үүсэх үндэслэл

5.1. Барьцаа нь хуульд заасан үндэслэлээр, эсхүл барьцаалагч, барьцаалуулагчийн хооронд байгуулсан гэрээний дагуу үүснэ.

6 дугаар зүйл. Барьцаагаар хангагдах үүрэг

6.1. Зээлийн болон бусад үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар барьцааны гэрээ байгуулж болно.

7 дугаар зүйл. Барьцаагаар хангах шаардлага

7.1. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцаагаар Иргэний хуулийн 165.6-д зааснаас гадна дараахь шаардлагыг хангана:

7.1.1. нэмэгдүүлсэн хүү;

7.1.2. барьцааны зүйлийг худалдахад гарсан зардал;

7.1.3. улсын тэмдэгтийн хураамж,

нөхөн төлүүлэх шүүхийн зардал.

7.2. Хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцаагаар хангагдах шаардлагын хэмжээ нь энэ хуулийн 7.1-д заасан хураамж, зардал, Иргэний хуулийн 165.6-д заасан хохирол, анз, хүүгийн нийлбэрээс хэтрэхээргүй байна.

7.3. Гэрээнд барьцаагаар хангагдах шаардлагын хэмжээг тусгайлан тогтоосон бол ийхүү тогтоосноос илүү гарсан хэсгийг энэ хуулийн 7.1, 7.2 дахь хэсэг, 8 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд барьцаалуулагч хариуцахгүй.

8 дугаар зүйл. Барьцаалагчийн нэмэгдэл зардал

8.1. Барьцааны зүйлийг арчлан хамгаалахад гарсан зардал, уг эд хөрөнгөтэй холбоотойгоор төлсөн татвар, хураамж, төлбөр зэрэг барьцааны гэрээнд заасан буюу барьцаалагчийн зайлшгүй гаргасан зардлыг барьцааны зүйлээс гаргуулж болно.

9 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг барьцаалуулах

9.1. Барьцаалуулагч өөрийн өмчлөлд байгаа

¹ Монгол Улсын Үндсэн хууль-Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн

² Иргэний хууль-Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн



Иргэний хуулийн 84.3-т заасан үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг барьцаалуулах эрхтэй.

9.2. Барьцааны гэрээг байгуулахдаа бусад этгээдийн зөвшөөрлийг урьдчилан авахаар хуульд заасан бол зөвшөөрлийг хуульд заасан холборээр авсан байна.

9.3. Үүрэг гүйцэтгэгч /түрээслэгч, хөлслөгч/ нь үл хөдлөх эд хөрөнгийг түрээслэх, хөлслөх эрхийг гагцхүү үүрэг гүйцэтгүүлэгч /түрээслүүлэгч, хөлслүүлэгч/-ийн бичгээр өгсөн зөвшөөрөлтэйгээр барьцаалуулж болно.

9.4. Хуулийн этгээдийн өмчлөлд байгаа эд хөрөнгийг барьцаалуулах шийдвэрийг хууль буюу дүрэмд заасан эрх бүхий этгээд гаргана.

9.5. Төрийн өөрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалуулах шийдвэрийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд¹ заасан эрх бүхий этгээд гаргана.

9.6. Дор дурдсан үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалуулахыг хориглоно:

9.6.1. иргэний гүйлгээнээс хасагдсан;

9.6.2 хуульд заасны дагуу тухайн хөрөнгөөс төлбөр гаргуулж үл болох;

9.6.3 хуульд заасан журмын дагуу хувьчлах шаардлагатай, эсхүл хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалтад орсон.

10 дугаар зүйл. Дундын өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг барьцаалуулах

10.1. Хамтран өмчлөх дундын өмчлөлд байгаа үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг барьцаалуулахад барьцааны зүйлийн өмчлөгч тус бүрийн зөвшөөрлийг бичгээр авна.

10.2. Үл хөдлөх эд хөрөнгө дундаа хэсгээр өмчлөгч өөрт оногдох хэсгээ барьцаалуулахад Иргэний хуулийн 108.3-т заасны дагуу бусад өмчлөгчид мэдэгдэнэ.

10.3. Энэ хуулийн 10.2-т заасан өмчлөгч өөрт оногдох хэсгээ барьцаалагчийн шаардлагаар худалдах бол дундаа хэсгээр өмчлөх бусад өмчлөгч тухайн хэсгийг Иргэний хуулийн 108.6-108.8 дахь хэсэг, 490 дүгээр зүйлд заасны дагуу тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхтэй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ БАРЬЦААНЫ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

11 дүгээр зүйл . Барьцааны гэрээний агуулга

11.1. Барьцааны гэрээ /цаашид "гэрээ" гэх/-г Иргэний хуулийн нийтлэг журам, энэ хуулийг баримтлан бичгээр байгуулах бөгөөд түүнд Иргэний хуулийн 156.2-т зааснаас гадна дараахь зүйлийг тусгана:

11.1.1. барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ, хэрэв үнэ буюу төлбөрийн хэмжээг урьдчилан тогтоогоогүй бол түүнийг тодорхойлох журам;

11.1.2. барьцаагаар хангагдах

үүргийг гүйцэтгэх хугацаа, үүрэг нь өөр гэрээнд үндэслэсэн бол уг гэрээний талууд, гэрээг байгуулсан он, сар, өдөр, түүнтэй холбоотой бусад нөхцөл;

11.1.3. Барьцааны зүйлийн байршил, тухайн зүйл нь барьцаалуулагчийн өмч мөн болохыг нотлох баримт, эд хөрөнгийн өмчлөх эрхийг бүртгэсэн байгууллагын нэр, өмчлөх эрхийн гэрчилгээний дугаар;

11.1.4. барьцааны зүйлийг өөр этгээдэд барьцаалуулсан эсэх тухай лавлагаа;

11.1.5. барьцаагаар хангагдах үүргийг хэсэгчлэн гүйцэтгэх бол төлбөр гүйцэтгэх хугацаа, давтамж, хэмжээ, эсхүл тэдгээрийг тодорхойлох журам;

11.1.6. барьцааны шаардлагыг хангах журам;

11.1.7. барьцаалагчийн эрх нь барьцаал-бараар гэрчлэгдэх эсэх тухай заалт;

11.1.8. барьцааны зүйл нь үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрх бол тухайн эрхийг олж авсан гэрээний үндсэн нөхцөл, хугацаа;

11.1.9. барьцааны зүйлтэй холбоотой гуравдагч этгээдийн эд хөрөнгийн эрх;

11.1.10. бусад.

11.2. Хуульд заасан бөгөөд талууд гэрээгээр тохиролцсон бол барьцааны зүйлээс шаардлагыг шүүхээс гадуур хангаж болно.

11.3. Энэ хуулийн 11.2-т заасан гэрээнд барьцааны зүйлийг шүүхээс гадуур худалдах аргын талаар нарийвчлан заана.

12 дугаар зүйл. Гэрээ бүртгүүлэх

12.1. Гэрээг улсын бүртгэлийн тухай хууль тогтоомжид заасны дагуу бүртгүүлнэ.

12.2 Энэ хуулийн 11 дүгээр зүйл болон улсын бүртгэлийн тухай хууль тогтоомжид заасан журмыг зөрчсөн гэрээг улсын бүртгэлд бүртгэхийг хориглоно.

12.3. Улсын бүртгэлд бүртгүүлэх журмыг зөрчиж бүртгүүлсэн гэрээ хүчин төгөлдөр бус байна.

13 дугаар зүйл. Барьцааны зүйлийн талаархи гуравдагч этгээдийн эрхийг барьцаалагчид мэдэгдэх

13.1. Барьцаалуулагч нь барьцааны зүйлтэй холбоотой гуравдагч этгээдийн түрээслэх болон бусад хязгаарлагдмал эрхийн талаар барьцаалагчид бичгээр мэдэгдэх бөгөөд ийнхүү мэдэгдээгүй бол барьцаалагч нь гэрээнд өөрчлөлт оруулах буюу үүргийг хугацаанаас нь өмнө гүйцэтгэхийг шаардах эрхтэй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ БАРЬЦААЛБАР

14 дүгээр зүйл. Барьцаалбар

14.1.Хууль ёсны эзэмшигчийн дор дурдсан эрхийг гэрчилсэн зөвшөөрлийн, биет үнэт цаасыг барьцаалбар гэнэ.

14.1.1. өөр нотолгоо шаардахгүйгээр үл хөдлөх эд хөрөнгийн барьцаагаар хангагдсан мөнгөн төлбөрийн үүргийн биелолтийг

¹ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль-Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1996 оны 11 дугаарт нийтлэгдсэн.

хүлээн авах, шаардах эрх;

14.1.2. үндсэн үүргийн гүйцэтгэлийг хангаж байгаа үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны эрх.

14.2. Хуульд заасан тохиолдолд барьцаалбар үйлдэнэ.

15 дугаар зүйл. Барьцаалбарын агуулга

15.1. Барьцаалбарт дараахь зүйлийг тусгана:

15.1.1. "Барьцаалбар" гэсэн гарчиг ;

15.1.2. барьцаалуулагч нь иргэн бол түүний овог, эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газар, хуулийн этгээд бол түүний оноосон нэр, улсын бүртгэлийн дугаар, оршин байгаа газар;

15.1.3. анхны барьцаалагчийн оноосон нэр, оршин байгаа газар;

15.1.4. барьцаалуулагч нь гуравдагч этгээд бол үндсэн үүргийн үүрэг гүйцэтгэгчийн овог, эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, оршин суугаа газар, хуулийн этгээд бол түүний оноосон нэр, улсын бүртгэлийн дугаар, оршин байгаа газар;

15.1.5. барьцааны эрх үүссэн үндэслэл, он, сар, өдөр, газар;

15.1.6. барьцаагаар хангагдах үүргийн болон хүүгийн хэмжээ, эсхүл тэдгээрийг тодорхойлох арга;

15.1.7. барьцаагаар хангагдах үүргийг хугацаанаас нь өмнө гүйцэтгэж болох эсэх тухай заалт;

15.1.8. барьцааны зүйлийн нэр, түүний шинж байдлын тодорхойлолт, байршил, эрхийн улсын бүртгэлийн дугаар;

15.1.9. үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрх барьцаалсан бол тухайн үл хөдлөх эд хөрөнгийн талаархи энэ хуулийн 15.1.8-д заасан мэдээлэл, уг эрхийн хүчинтэй байх хугацаа;

15.1.10. барьцааны зүйлтэй холбоотой гуравдагч этгээдийн эд хөрөнгийн эрх байгаа эсэх тухай заалт;

15.1.11. барьцаалбарыг түүний хууль ёсны эзэмшигч бусдад шилжүүлэхийг барьцаалуулагч зөвшөөрсөн тухай заалт;

15.1.12. барьцааны зүйлээс шаардлагыг хангах журам;

15.1.13. барьцаалбар үйлдсэн он, сар, өдөр;

15.1.14. барьцаалуулагчийн, хэрэв барьцаалуулагч нь гуравдагч этгээд бол барьцаалуулагч болон барьцаагаар хангагдсан үүргийн үүрэг гүйцэтгэгчийн гарын үсэг.

15.2. Энэ хуулийн 15.1-д заасан мэдээллийн аль нэгийг тусгаагүй барьцаалбар хүчин төгөлдөр бус байна.

15.3. Энэ хуулийн 15.1-д зааснаас бусад мэдээллийг талууд харилцан тохиролцож барьцаалбарт тусгаж болно.

16 дугаар зүйл. Барьцаалбар үйлдэх

16.1. Барьцаалуулагч нь барьцаалбарыг улсын бүртгэлийн байгууллагаас баталсан загварын дагуу нэг хувь үйлдэж гэрээний хамт улсын

бүртгэлийн байгууллагад өгнө.

16.2. Улсын бүртгэлийн байгууллага барьцаалбарт гэрээ байгуулсан он, сар, өдөр, газрыг тэмдэглэж, хуудас бүрт гарын үсэг зурж, тэмдэг дарах бөгөөд хуулбарыг нь хувийн хэрэгт авч, ажлын 5 өдрийн дотор барьцаалагчид эх хувийг хүргүүлнэ.

16.3. Иргэн хувийн өмчийн газар, эсхүл түүнтэй холбоотой эрхийг барьцаалсан буюу түрээсэлсэн бол барьцаалбар үйлдэх, бүртгүүлэхийг хориглоно.

16.4. Энэ хуулийн 16.3-т заасан журмыг зөрчиж үйлдсэн аливаа хэлцэл, баримт бичиг хүчин төгөлдөр бус байна.

17 дугаар зүйл. Барьцаалбарт өөрчлөлт оруулах

17.1. Үүрэг гүйцэтгэгч, барьцаалуулагч, барьцааны хууль ёсны эзэмшигч харилцан тохиролцож барьцаалбарт дараахь байдлаар өөрчлөлт оруулж болно:

17.1.1. барьцаалбарын агуулгад оруулсан өөрчлөлтийг бичгээр үйлдэж эх хувьд хавсаргах, уг хавсралт нь тухайн барьцаалбарын салшгүй хэсэг болох тухай барьцаалбарт тэмдэглэл үйлдэх;

17.1.2. холбогдох өөрчлөлтийг тусгасан шинэ барьцаалбарыг энэ хуулийн 15.16 дугаар зүйлд заасны дагуу үйлдэж, хуучин барьцаалбарыг хүчингүй болгох.

17.2. Улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 17.1.1-д заасны дагуу барьцаалбарт оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор холбогдох өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх бөгөөд ийнхүү бүртгэхэд үйлчилгээний хөлс, төлбөр, хураамж авахгүй.

17.3. Энэ хуулийн 17.1.2-т заасны дагуу хүчингүй болсон барьцаалбарыг улсын бүртгэлийн байгууллага хураан авч, архивлан хадгална.

18 дугаар зүйл. Барьцаалбараар баталгаажсан эрхийг хэрэгжүүлэх, барьцаагаар хангагдах үүргийг гүйцэтгэх

18.1. Барьцаалбарын хууль ёсны эзэмшигч нь түүгээр гэрчлэгдсэн эрхээ хэрэгжүүлэхдээ тухайн барьцаалбараар үүрэг хүлээсэн этгээдийн шаардсанаар барьцаалбарыг түүнд танилцуулж эзэмших эрхээ нотолно.

18.2. Үүрэг гүйцэтгэгч нь барьцаагаар хангагдах үүргийг бүрэн биелүүлсний дараа барьцаалагч нь барьцаалбарыг түүнд шилжүүлэн өгөх үүрэгтэй.

18.3. Барьцаалуулагч нь үүргийг хэсэгчлэн гүйцэтгэсэн тухай тэмдэглэлийг барьцаалбарт тусгах буюу санхүүгийн зохих баримт бичгээр нотолно.

18.4. Энэ хуулийн 18.3-т заасан шаардлагыг хангаагүй бол мөн хуулийн 38.6-д зааснаас бусад тохиолдолд уг үүргийг гүйцэтгээгүйд тооцно.

18.5. Үүрэг гүйцэтгэгч нь төлбөрийг зохих хуваарийн дагуу хэсэгчлэн хийхээр гэрээнд заасан бол уг үүрэг зохих ёсоор гүйцэтгэнэ.

18.6. Үүрэг гүйцэтгэгч нь дараахь



тохиолдолд барьцаалбараар гэрчлэгдсэн үүрэг гүйцэтгэхийг шаардаж байгаа этгээдийн өмнө уг үүргийг гүйцэтгэхээс татгалзах эрхтэй:

18.6.1. Барьцаалбарыг шилжүүлсэн тухай хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах, эсхүл уг үндэслэлээр хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцоноос үүссэн үр дагаврыг арилгах тухай нэхэмжлэлээр шүүх хэрэг үүссэн хянаж байгаа;

18.6.2. Барьцаалбарыг шинээр олгох журыг зөрчсөний улмаас түүнийг хүчингүйд тооцож, барьцаалбар дээр нэр заагдсан үүрэг гүйцэтгэгч нь түүгээр хүлээсэн үүргийг хариуцахгүй болсон.

18.7. Энэ хуулийн дагуу хүчингүй болсон барьцаалбарыг хүлээн авмагц улсын бүртгэлийн байгууллага барьцаалбарын нүүрэн талд нь "хүчингүй болсон" гэсэн тэмдэг дарж, холбогдох хувийн хэрэгт хавсаргаж архивлан хадгална.

18.8. Үүрэг гүйцэтгэгч нь энэ хуулийн 18.6 дахь хэсэг болон барьцаалбарт зааснаас бусад үндэслэлээр үүрэг гүйцэтгэхээс татгалзах эрхгүй.

18.9. Энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу барьцаалбарыг шинээр эзэмшсэн этгээд нь энэ тухай уг барьцаалбараар эрх эдэлж, үүрэг хүлээх этгээдэд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

18.10. Үүргээ зохих ёсоор гүйцэтгэсэн үүрэг гүйцэтгэгч энэ тухай баримтыг хавсаргаж барьцаалбарыг улсын бүртгэлийн байгууллагад хүлээлгэж өгсөн бөгөөд хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй, эсхүл түүний хууль ёсны эзэмшигч өөрөөр нотлоогүй бол барьцаагаар хангагдах үүргийг гүйцэтгэсэн гэж үзнэ.

19 дүгээр зүйл. Барьцаалбар дахин олгох

19.1. Барьцаалбарыг гэссэн буюу үрэгдүүлсэн бол барьцаалуулагч дор дурдсан үндэслэлээр дахин олгоно:

19.1.1. хууль ёсны эзэмшигч нь барьцаалбарыг дахин олгох тухай хүсэлтийг гэрээгээр барьцаалуулагчид ирүүлсэн;

19.1.2. гэссэн буюу үрэгдүүлсэн баримт бичгийг дахин олгох тухай нэхэмжлэлийг онцгой ажиллагааны журмаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд⁴ заасны дагуу хянан хэлэлцэж шүүх зохих шийдвэр гаргасан.

19.2. Барьцаалуулагч барьцаалбарыг дахин үйлдэж "шинээр олгов" гэсэн тэмдэглэлтэйгээр улсын бүртгэлийн байгууллагад шилжүүлнэ.

19.3. Энэ хуулийн 19.2-т заасны дагуу дахин үйлдсэн барьцаалбарыг улсын бүртгэлийн байгууллага бүртгэж, хууль ёсны эзэмшигчид нь хүргүүлнэ.

19.4. Шинээр олгосон болон хуучин барьцаалбарын агуулга бүрэн тохирсон байх бөгөөд энэ шаардлагыг бүрэн хангаагүйгээс учирсан хохирлыг барьцаалбар шинээр үйлдсэн этгээд хариуцна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БАРЬЦААНЫ ЗҮЙЛИЙГ АШИГЛАХ,

ХАМГААЛАХ

20 дугаар зүйл. Барьцааны зүйлийг ашиглах

20.1. Барьцаалуулагч барьцааны зүйлийг зориулалтынх нь дагуу ашиглах эрхтэй.

20.2. Энэ хуулийн 20.1-д заасан барьцаалуулагчийн эрхийг хязгаарласан гэрээний нөхцөл хүчин төгөлдөр бус байна.

20.3. Гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцаалуулагч нь барьцааны зүйлийг чанар байдлыг нь дордуулахгүйгээр, хэвийн элэгдэл хорогдлоос илүүгээр өртгийг нь бууруулахгүйгээр ашиглах үүрэгтэй.

20.4. Барьцаалуулагч нь Иргэний хуулийн 157.5-1д заасны дагуу барьцааны зүйлээс олох орлого, үр шимийг хүртэх эрхтэй бөгөөд гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцаалагч нь эдгээр орлого, үр шимийн талаар аливаа эрх эдлэхгүй.

21 дүгээр зүйл. Барьцааны зүйлийг арчлах, засварлах

21.1. Гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцаалуулагч нь уг гэрээ дуусгавар болох хүртэлх хугацаанд барьцааны зүйлийг арчлан хамгаалж, хууль болон эрх зүйн бусад актаар тогтоосон хугацаа, журмын дагуу, хэрэв хугацаа заагаагүй бол зохистой хугацаанд урсгал болон их засвар хийж, гарсан зардлыг нь хариуцна.

21.2. Гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцааны зүйлийн хийц, зориулалт, загварыг нь өөрчлөхийг хориглоно.

22 дугаар зүйл. Барьцааны зүйлийн даатгал

22.1. Хуульд өөрөөр заагаагүй бол барьцааны зүйлийг даатгалд даатгуулах эсэхийг талууд гэрээгээр тохиролцоно.

22.2. Даатгалын тохиолдол бий болсон бол даатгагч нь Иргэний хуулийн 170.3, 170.4-т заасан арга хэмжээ авах бөгөөд барьцаалагч нь даатгалын нөхөн төлбөрөөс өөрийн шаардлагыг тэргүүн ээлжинд хангуулах давуу эрхтэй.

23 дугаар зүйл. Барьцааны эрхийг хамгаалах

23.1. Барьцааны зүйлийн өмчлөх болон бусад эрхийн талаар шүүх /арбитр/-ээс хэрэг үүссэн барьцаалуулагчийг хариуцагчаар татсан бол барьцаалуулагч нь энэ тухай барьцаалагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

23.2. Энэ хуулийн 23.1-д заасан тохиолдолд барьцаалуулагч нь Иргэний хуулийн 9.4-т заасны дагуу эрхээ хамгаална.

23.3. Барьцаалуулагч нь энэ хуулийн 23.2-т заасны дагуу барьцааны зүйлийн талаархи өөрийн эрхийг хамгаалахаас татгалзсан, эсхүл хамгаалаагүй бол барьцаалагч нь итгэмжлэлгүйгээр барьцаалуулагчийн нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргах, түүнтэй холбоотойгоор гарсан зардлаа нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.

23.4. Барьцааны зүйл гуравдагч этгээдийн хууль бус эзэмшилд орсон бол барьцаалагч нь Иргэний хуулийн 90.2, 106.1 дэх хэсэг болон 95

⁴ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

дугаар зүйлд нийцүүлэн уг барьцааны зүйлийг барьцаалуулагчийн эзэмшилд шилжүүлэхийн тулд бусдын хууль бус эзэмшлээ шаардан харгуулах эрхтэй.

24 дүгээр зүйл. Барьцааны зүйлийн чанар байдлыг шалгах

24.1. Барьцаалагч нь барьцаалуулагчид урьдчилан мэдэгдсэн үндсэн дээр барьцааны зүйлийн чанар, арчлан хамгаалалтын нөхцөлийг баримтаар болон бодит байдлаар нь ажлын цагаар шалгах эрхтэй бөгөөд барьцаалагчийн энэхүү эрх нь барьцааны зүйл болох үл хөдлөх эд хөрөнгө барьцаалуулагчаас гуравдагч этгээдийн эзэмшилд түр шилжсэн тохиолдолд нэгэн адил хамаарна.

24.2. Барьцаалагч энэ хуулийн 24.1-д заасан эрхээ барьцааны зүйлийг эзэмшиж байгаа этгээдийн уг барьцааны зүйлийг ашиглах эрхэд саад учруулахгүйгээр хэрэгжүүлнэ.

25 дугаар зүйл. Барьцааны зүйлийг зохих ёсоор хамгаалаагүйгээс барьцаалагчид үүсэх эрх

25.1. Барьцаалуулагч нь барьцааны зүйлийг зориулалтын бусаар ашигласан, энэ хуулийн 20.2 дахь хэсэг, 21 дүгээр зүйл, Иргэний хуулийн 170.2-т заасан болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зөрчсөн тохиолдолд барьцаалагч тухайн үүргийг тогтоосон хугацаанд гүйцэтгэхийг түүнээс бичгээр шаардах эрхтэй.

25.2. Барьцаалуулагч энэ хуулийн 25.1-д заасан шаардлагыг хугацаанд нь биелүүлээгүй бол барьцаалагч барьцаагаар хангагдах үүргийг хугацаанаас нь өмнө гүйцэтгэхийг шаардах эрхтэй.

25.3. Барьцаалуулагч энэ хуулийн 25.2-т заасан шаардлагыг гэрээнд заасан хугацаанд, хэрэв гэрээнд тусгайлсан хугацаа заагаагүй бол нэг сэрэн хугацаанд хангахаас татгалзсан буюу хангаагүй бол барьцаалагч нь барьцааны зүйлээс үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шаардах эрхтэй.

26 дугаар зүйл. Барьцааны зүйл устсан, гэмтсэний үр дагавар

26.1. Гэрээнд өөрөөр заагаагүй бол гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас барьцааны зүйл гэмтэх, устгах эрсдэлийг барьцаалуулагч хүлээнэ.

26.2. Хууль буюу гэрээнд заасан дагуу барьцааны зүйлийг даатгуулсан бөгөөд уг эд хөрөнгө гэмтсэн буюу устсан бол барьцаалагч нь барьцаагаар хангагдах үүргийг хугацаанаас нь өмнө даатгалын нөхөн төлбөрөөс төлөхийг шаардах эрхтэй.

26.3. Гэмтсэн буюу устсан барьцааны зүйлийг сэргээх, эсхүл солих тухай барьцаалагч, барьцаалуулагч бичгээр гэрээ байгуулсан бөгөөд барьцаалуулагч нь тухайн гэрээний нөхцөлийг зохих ёсоор биелүүлсэн бол барьцаалагч энэ хуулийн 26.2-т заасан эрхийг эдлэхгүй.

ТАВДУГААР БҮЛЭГ

БАРЬЦААНЫ ЗҮЙЛИЙГ БУСДЫН ӨМЧЛӨЛ, ЭЗЭМШИЛ, АШИГЛАЛТАД ШИЛЖҮҮЛЭХ

27 дугаар зүйл. Барьцааны зүйлийг

бусдын өмчлөлд шилжүүлэх

27.1. Барьцаалуулагч нь Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийг баримтлан барьцааны зүйлийг гагцхүү барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр бусдын өмчлөлд шилжүүлэх эрхтэй.

27.2. Барьцаалбар олгосон бол барьцааны зүйлийг уг барьцаалбараар тодорхойлсон нөхцөлийн дагуу бусдын өмчлөлд шилжүүлж болно.

27.3. Барьцаалуулагч нь барьцааны зүйлийг өвлүүлэх эрхтэй бөгөөд энэ эрхийг нь хязгаарласан гэрээ хүчин төгөлдөр бус байна.

28 дугаар зүйл. Барьцааны зүйлийг бусдын өмчлөлд шилжүүлэхэд барьцааны шаардлага хэвээр хадгалагдах

28.1. Барьцааны зүйлийг энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан журмын дагуу өмчлөлдөө шилжүүлэн авсан этгээд өмнөх барьцаалуулагчийн эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

28.2. Хууль буюу гэрээгээр өв болон эрх залгамжлах, түүнчлэн хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсаны улмаас барьцааны зүйлийг өмчлөлд шилжүүлэн авсан этгээд нь тухайн гэрээгээр барьцаалуулагчийн хүлээх үүргийг өөртөө шилжүүлэн авсан эрх, өв хөрөнгийн үнийн дүнгийн хэмжээгээр хариуцна.

28.3. Энэ хуулийн 28.2-т заасан барьцааны зүйл хэд хэдэн этгээдийн өмчлөлд шилжсэн бол барьцааны зүйлийг хүлээн авагч тус бүр өөрт нь шилжиж ирсэн эд хөрөнгийн хэмжээгээр хувь тэнцүүлэн хариуцлага хүлээх бөгөөд хэрэв тухайн эд хөрөнгө нь үл хуваагдах буюу бусад үндэслэлээр барьцаалуулагчийн эрх хүлээн авагчдын хамтран өмчлөх дундын өмчлөлд шилжсэн бол эрх хүлээн авагч бүх этгээдийг хамтран барьцаалуулагч гэж үзнэ.

28.4. Барьцааны зүйлийг бусдад шилжүүлэх талаар тогтоосон журам зөрчсөн эсэхийг үл харгалзан тухайн барьцааг хүчинтэй гэж үзнэ.

29 дүгээр зүйл. Барьцааны зүйлийг бусдын өмчлөлд шилжүүлэх журам зөрчсөний үр дагавар

29.1. Барьцааны зүйлийг бусдад шилжүүлэхэд энэ хуулийн 27.1, 27.2-т заасан шаардлагыг зөрчсөн бол барьцаалагч нь дараахь шаардлагын аль нэгийг тавих эрхтэй:

29.1.1. Иргэний хуулийн 56.5, 56.6-д заасны дагуу барьцааны зүйлийг буцаах, хохирлыг арилгуулахаар ээлцлийг хүчингүй болгуулах;

29.1.2. барьцааны зүйл хэний эзэмшилд байгааг үл харгалзан түүгээр хангагдах үүргийг хугацаанаас нь өмнө барьцааны зүйлээс хангуулах.

29.2. Барьцааны зүйлийг шилжүүлэн авсан этгээд нь энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан журмыг зөрчсөн гэдгийг мэдэж байсан буюу мэдэх боломжтой байсан бол уг барьцаагаар хангагдах үүргийг зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх үүргийн гүйцэтгэлийг тухайн эд хөрөнгийн үнийн дүнгийн хэмжээнд холбогдох бусад үүрэг гүйцэтгэгчтэй хамтран хариуцна.

29.3. Барьцаалуулагч нь гуравдагч этгээд бөгөөд хуулиар тогтоосон журмыг зөрчиж барьцааны

зүйлийг бусдын өмчлөлд шилжүүлсэн бол үүргийн гүйцэтгэлийг эд хөрөнгийг шинээр өмчлөгч болон өмнөх барьцаалуулагчтай хамтран харууцна.

30. Дугаар зүйл. Барьцааны зүйлийг бусад этгээдийн эзэмшил, ашиглалтад шилжүүлэх

30.1. Барьцаалуулагч нь барьцааны зүйлийг үндсэн үүргийг гүйцэтгэх хугацааны дотор гуравдагч этгээдэд барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр түрээслэх, хөслөх, үнэ төлбөргүйгээр түр ашиглуулахаар бусдын эзэмшилд шилжүүлэх эрхтэй.

30.2. Хууль буюу гэрээнд заасны дагуу барьцаалагчийн шаардлагаар барьцааны зүйлийг худалдсан бол энэ хуулийн 30.1-д заасан барьцаалуулагчийн түрээслэх болон бусад эрх дуусгавар болно.

30.3. Барьцааны зүйлийг барьцаагаар хангагдах үүрэг гүйцэтгэх хугацаанаас хэтрүүлж болон өөр зориулалтаар бусад ашиглуулахдаа барьцаалуулагч нь барьцаалагчийн зөвшөөрлийг авна.

30.4. Барьцаалагчийн зөвшөөрөлгүйгээр энэ хуулийн 30.1-д заасан хугацаанаас хэтрүүлж гуравдагч этгээдэд эрх олгосон хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

30.5. Гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцааны зүйлийг бусдад ашиглуулсан нь барьцаалуулагчийг уг гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

31. Дүгээр зүйл. Барьцааны зүйлийг төрийн болон орон нутгийн өмчлөлд албадан шилжүүлснээс үүсэх үр дагавар

31.1. Барьцааны зүйлийг хуульд заасан үндэслэл, журмаар улсын болон орон нутгийн хэрэгцээнд дайчлан авсан, эсхүл нийгэмчилсний улмаас барьцаалуулагчийн өмчлөх эрх дуусгавар болсон бол төр, түүний эрх бүхий байгууллага нөхөх олговор, үнийг төлөх бөгөөд ийнхүү олгосон нөхөх олговор болон үнээр барьцаалагч өөрийн шаардлагыг хангуулах эрхтэй.

31.2. Энэ хуулийн 31.1-д заасан арга хэмжээ эрхийг нь хамгаалж чадаагүй гэж үзвэл барьцаалагч нь барьцаагаар хангагдах үүргийг хугацаанаас нь өмнө гүйцэтгэхийг шаардах эрхтэй.

31.3. Барьцаалуулагч гэмт хэрэг, хууль зөрчсөн бусад үйлдлийн улмаас барьцааны зүйлийг шүүхийн шийдвэрээр хураасан бол уг барьцаа хүчин төгөлдөр хэвээр үлдэх бөгөөд энэ тохиолдолд энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан журмыг хэрэглэнэ.

31.4. Энэ хуулийн 31.3-т заасан журмыг хэрэглэж эрх, ашиг сонирхолд нь хохирол учруулсан гэж үзвэл барьцаалагч нь барьцаагаар хангагдах үүргийг хугацаанаас нь өмнө гүйцэтгэхийг барьцаалуулагчаас шаардах, эсхүл хураалгасан эд хөрөнгөө шаардлагаа хангуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

32. Дугаар зүйл. Барьцааны зүйлийг хууль бус эзэмшлээс гаргуулах

32.1. Улсын бүртгэлийн байгууллага хууль зөрчсөний улмаас барьцаалуулагч нь барьцааны зүйлийг хууль бусаар олж авсан бөгөөд уг зүйлийн хууль ёсны өмчлөгч нь үл хөдлөх эд хөрөнгөө барьцаалуулагчийн хууль бус эзэмшлээс гаргуулж

авсан бол тухайн эд хөрөнгийн хувьд барьцааны эрх дуусгавар болно.

32.2. Энэ хуулийн 32.1-д заасан тохиолдолд барьцаалагч нь шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсны дараа барьцаагаар хангагдах үүргийн гүйцэтгэлийг барьцаалуулагч болон улсын бүртгэлийн байгууллагаас шаардах эрхтэй.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙГ ДАВХАР БАРЬЦААЛАХ

33 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийг давхар барьцаалах

33.1. Хүчинтэй байгаа өмнөх гэрээгээр хориглоогүй бол барьцаалуулагч нь барьцааны зүйлийг бусад этгээдэд давхар барьцаалах эрхтэй.

33.2. Энэ хуулийн 33.1-д заасан тохиолдолд барьцаалагчийн шаардлагыг улсын бүртгэлд бүртгэсэн дарааллаар хангана.

33.3. Өмнөх барьцааны гэрээнд дараачийн барьцааны гэрээний нөхцөлийг тусгасан бол дараачийн барьцааны гэрээг байгуулахдаа уг нөхцөлийг заавал тусгана.

33.4. Энэ хуулийн 33.3-т заасныг зөрчиж байгуулсан гэрээг дараачийн барьцаалагч урьдчилан мэдэж байсан эсэхээс үл хамааран шүүх өмнөх барьцаалагчийн нэхэмжлэлээр дараачийн барьцааны гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцно.

33.5. Хэрэв өмнөх болон дараачийн гэрээний барьцаалагч, барьцаалуулагч нь нэг этгээд байвал энэ зүйлд заасан журам хамаарахгүй.

34 дүгээр зүйл. Өмнөх болон дараачийн барьцааны тухай барьцаалагчид мэдэгдэх, өмнөх гэрээг өөрчлөх

34.1. Барьцаалуулагч нь дараачийн барьцаалагчтай гэрээ байгуулахдаа тухайн барьцааны зүйлийн хүчинтэй бүх барьцааны тухай түүнд мэдэгдэх үүрэгтэй.

34.2. Барьцаалуулагч энэ хуулийн 34.1-д заасан үүргээ биелүүлээгүй бөгөөд дараачийн барьцаалагч тухайн үл хөдлөх эд хөрөнгийн өмнөх барьцаа хүчинтэй байгаа тухай мэдэж байсан гэдгийг барьцаалуулагч нотолсноос бусад тохиолдолд дараачийн барьцаалагч нь гэрээгээ цуцалж, учирсан хохирлыг нөхөн төлөхийг шаардах эрхтэй.

34.3. Барьцаалуулагч нь барьцааны зүйлийг давхар барьцаалуулсан тухай өмнөх гэрээний барьцаалагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

34.4. Барьцаагаар хангагдах шаардлагын хэмжээг нэмэгдүүлэх талаар өмнөх гэрээнд заагаагүй бол дараачийн гэрээг байгуулсны дараа өмнөх барьцаалагчийн шинэ шаардлагыг хангах, эсхүл уг гэрээгээр хангагдах шаардлагын хэмжээг нэмэгдүүлэх өөрчлөлтийг гагцхүү дараачийн гэрээний барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр хийнэ.

35 дугаар зүйл. Давхар барьцааг бүртгэх

35.1. Давхар барьцааны улсын бүртгэлийн Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль¹ заасан журмаар хийнэ.

¹ Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2003 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

35.2. Талууд барьцааны дараачийн гэрээнд тухайн үл хөдлөх эд хөрөнгийн өмнөх барьцааны улсын бүртгэлийн тухай заана.

35.3. Тухайн эд хөрөнгийн дараачийн бүх барьцааны тухай өмнөх барьцааны улсын бүртгэлд тэмдэглэгээ хийнэ.

36 дугаар зүйл. Өмнөх болон дараачийн барьцааны талаархи барьцаалагчийн шаардлагыг хангах

36.1. Барьцаалагчийн шаардлагыг барьцааны зүйлийн үнээс улсын бүртгэлд бүртгүүлсэн дарааллаар хангуулна.

36.2. Хэрэв өмнөх барьцаалагч давуу эрхээ эдлээгүй бол барьцааны зүйлээс өөрийн шаардлагыг тэргүүн ээлжинд хангуулах эрх нь дараачийн барьцаалагчид шилжинэ.

36.3. Барьцаалагч нь тухайн эд хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шаардахын өмнө бусад барьцаалагчид энэ тухай бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

36.4. Барьцаалагчийн аль нэг нь барьцааны зүйлээс үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шаардлага гаргасан бол өмнөх болон дараачийн барьцаагаар хангагдах үүргийг шаардах хугацаа болоогүй байсан ч бусад барьцаалагч тухайн барьцааны зүйлээс нэгэн зэрэг хангуулахаар шаардаж болно.

36.5. Хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бөгөөд бусад барьцаалагч зөвшөөрсөн бол барьцаа тус бүрийг хангах шаардлагыг тухайн үүргийг гүйцэтгэх хугацааны дарааллын дагуу хангана.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ШААРДАХ ЭРХ, БАРЬЦААЛБАРЫГ ШИЛЖҮҮЛЭХ, БАРЬЦААЛАХ

37 дугаар зүйл. Шаардах эрхийг шилжүүлэх

37.1. Барьцаалагч шаардах эрхээ шилжүүлэхэд Иргэний хуулийн 123 дугаар зүйлийг баримтална.

38 дугаар зүйл. Барьцаалбарыг шилжүүлэх

38.1. Барьцаалагч нь барьцаалбарыг худалдах, барьцаалах зэргээр бусдад шилжүүлж болно.

38.2. Барьцаалбараар гэрчлэгдсэн эрхийг түүнд бичилт хийх замаар шилжүүлэх бөгөөд уг барьцаалбар шилжсэнээр шаардах эрх хамт шилжинэ.

38.3. Барьцаалбарт заасан эрхийг шилжүүлэхдээ уг барьцаалбарт шинээр эрх олж авсан этгээд нь иргэн бол түүний овог, эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, хуулийн этгээд бол түүний оноосон нэр, эрх шилжүүлсэн үндэслэлийн талаархи бичилт хийнэ.

38.4. Энэ хуулийн 38.3-т заасан бичилтэд уг барьцаалбарт заасан барьцаалагч гарын үсэг зурх бөгөөд барьцаалбарын бичилт нь анхных биш бол өмнөх бичилтэд заасан барьцаалбар эзэмшигч гарын үсэг зурж, нотариатаар гэрчлүүлнэ.

38.5. Барьцаалбараар гэрчлэгдсэн эрхийг өөр этгээдэд шилжүүлснээр уг барьцаалбараар гэрчлэгдсэн бүх эрх хамт шилжсэнд тооцно.

38.6. Барьцаалуулагч барьцаалбарыг шилжүүлэхээс өмнө үндсэн гэрээний үүргээ хэсэгчлэн биелүүлсэн бол гэрээний үүргийг тухайн хэмжээгээр гүйцэтгэсэн гэж үзнэ.

38.7. Хэрэв барьцаалбарыг эзэмших эрх нь барьцаалбарт заасан эзэмшигчийн эрхийг шилжүүлэх тухай гэрээ болон өмнөх эзэмшигчийн уг барьцаалбарт хийсэн сүүлчийн бичилтэд үндэслэсэн бол шинэ эзэмшигчийг хууль ёсны гэж үзнэ.

38.8. Гуравдагч этгээд Иргэний хуулийн 210.4-т заасны дагуу үүрэг гүйцэтгэгчийн барьцаагаар хангагдах үүргийг бүрэн гүйцэтгэсэн бол уг этгээд барьцаалбарт заасан эрхийг өөртөө шилжүүлэхийг шаардах эрхтэй бөгөөд энэ шаардлагыг хангахаас татгалзвал шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

38.9. Барьцаалбарыг шилжүүлж байгаа этгээд нь энэ тухай болон барьцаалбарын шинэ хууль ёсны эзэмшигчийн нэр, хаяг, дараагийн төлбөрийг хийх хугацааны талаар барьцаалуулагч, үүрэг гүйцэтгэгчид бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

39 дүгээр зүйл. Барьцаалбар шилжсэнийг бүртгэх

39.1. Хууль болон гэрээнд заасан бол барьцаалбарыг энэ хуулийн 38.1-д заасан журмын дагуу шилжүүлэн авсан хууль ёсны эзэмшигч нь энэ тухайгаа улсын бүртгэлд бүртгүүлнэ.

39.2. Энэ хуулийн 39.1-д заасан тохиолдолд хууль ёсны эзэмшигч нь барьцаалбар, мэдүүлгийг улсын бүртгэлийн байгууллагад гаргана.

39.3. Улсын бүртгэлийн байгууллага барьцаалбарын эх хувь, мэдүүлгийг хүлээн авснаас хойш ажлын нэг өдрийн дотор барьцаалбар болон улсын бүртгэлд өөрчлөлт оруулан, тэмдэглэл үйлдэж, барьцаалбарыг хууль ёсны эзэмшигчид нь өгнө.

39.4. Хууль ёсны эзэмшигч барьцаалбарыг өөрийн нэр дээр бүртгүүлэхэд төлбөр, хураамж төлөхгүй.

40 дүгээр зүйл. Барьцаалбарыг барьцаалах

40.1. Хууль ёсны эзэмшигч нь барьцаалбарыг гагцхүү өөрийн гүйцэтгэх үүргийн баталгаа болгон бусдад барьцаалуулж болно.

40.2. Барьцаалбарыг барьцаалуулах бол уг барьцаалбарт энэ тухай тэмдэглэгээ хийнэ.

40.3. Барьцаалбарыг барьцаалагчийн эзэмшилд шилжүүлэхгүйгээр барьцаалуулсан бол уг барьцаалбараар гүйлгээ хийхдээ Иргэний хуулийн 158 дугаар зүйлийг баримтална.

40.4. Барьцаалбарыг барьцаалагчид шилжүүлэх бол талууд гэрээнд дараах нөхцөлийг тусгана:

40.4.1. барьцааны зүйлийг Иргэний хуулийн 158 дугаар зүйлд зааснаар гаргуулах;

40.4.2. барьцаалбарт заасан эрхийг энэ хуулийн 38 дугаар зүйлд заасан нөхцөл, журмаар шилжүүлэх;

40.4.3. барьцаалагч нь барьцаалбараар хангагдах үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар барьцаалбарыг худалдаж болох тухай түүнд тусгай бичилт хийх тухай заалт.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ БАРЬЦААНЫ ЗҮЙЛЭЭС ХАНГУУЛАХ

41 дүгээр зүйл. Үүргийн гүйцэтгэлийг шаардах

41.1. Үүрэг гүйцэтгэгч болон барьцаалуулагч нь үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол барьцаалагч нь үүргийн гүйцэтгэлийг шаардах эрхтэй.

41.2. Энэ хуулийн 41.1-д заасан барьцаалагчийн шаардлагыг биелүүлээгүй бол үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулахаар барьцааны зүйлийг худалдахыг шаардах эрхтэй.

41.3. Барьцааны зүйлийг давхар барьцаалсан бол барьцаалагч нь энэ хуулийн 41.2-т заасан эрхээ хэрэгжүүлэхдээ бусад барьцаалагч болон барьцаалуулагчид, барьцаалуулагч нь гуравдагч этгээд бол үүрэг гүйцэтгэгчид, барьцааны зүйл нь түрээсийн зүйл бол түрээслүүлэгчид урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.

42 дугаар зүйл. Барьцаалуулагчид мэдэгдэл хүргүүлэх

42.1. Барьцаалагч нь энэ хуулийн 41.1-д заасны дагуу үүргийн гүйцэтгэлийг шаардах тухайгаа барьцаалуулагч болон үүрэг гүйцэтгэгчид бичгээр мэдэгдэнэ.

42.2. Барьцаалуулагч болон үүрэг гүйцэтгэгч нь мэдэгдэлд заасан хугацаанд хариу өгөөгүй бол барьцаалагч нь энэ тухай улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж барьцаалуулагч болон тухайн барьцааны зүйлтэй холбоотой эрхээ бүртгүүлсэн гуравдагч этгээдэд үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах тухайгаа бичгээр мэдэгдэнэ.

42.3. Энэ хуулийн 42.2-т заасан мэдэгдэлд 30 хоногийн дотор барьцаалуулагч хариу өгөөгүй буюу үүргээ биелүүлээгүй бол барьцаалагч нь барьцааны зүйлийг худалдах ажиллагааг эхлүүлнэ.

42.4. Энэ хуулийн 42.2-т заасан мэдэгдлийн маягт болон мэдэгдлийг хүргүүлэх журмыг бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

43 дугаар зүйл. Барьцааны зүйлийг худалдах журам

43.1. Барьцааны зүйлийг талууд шүүхээс гадуур, эсхүл шүүхийн журмаар худалдаж болно.

44 дүгээр зүйл. Барьцааны зүйлийг шүүхээс гадуур худалдах

44.1. Барьцааны зүйлийг шүүхээс гадуур худалдах ажиллагааг хууль болон талуудын хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна.

44.2. Барьцааны зүйлийг шүүхээс гадуур худалдахдаа энэ хуулийн 45 дугаар зүйлд заасан шууд худалдах, 46 дугаар зүйлд заасан дуудлага худалдааны аргын аль нэгийг хэрэглэнэ.

44.3. Дараачийн барьцааны хувьд өмнөх барьцаалагч зөвшөөрсөн бол барьцааны зүйлийг шүүхээс гадуур худалдаж болно.

44.4. Дараахь барьцааны зүйлийг шүүхээс гадуур худалдахыг хориглоно:

44.4.1. газар;

44.4.2. улсын бүртгэлд бүртгүүлсэн буюу бүртгүүлэл зохих үл хөдлөх хөрөнгө болох түүх, урлаг, соёлын үнэт зүйлс.

45 дугаар зүйл. Барьцааны зүйлийг шууд худалдах

45.1. Барьцаалагч, барьцаалуулагч нь энэ хуулийн 11.2-т зааснаар харилцан тохиролцсон бол барьцааны зүйлийг шууд худалдаж болно.

46 дугаар зүйл. Барьцааны зүйлийг шүүхээс гадуур дуудлага худалдаагаар худалдах

46.1. Барьцааны зүйлийг шүүхээс гадуур дуудлага худалдаагаар худалдах ажиллагааг барьцаалагч, барьцаалуулагчийн харилцан тохиролцож сонгосон, ийнхүү тохиролцоогүй бол барьцаалагчийн сонгосон үл хөдлөх эд хөрөнгө худалдах асуудлаар мэргэшсэн, хөндлөнгийн хуулийн этгээд гэрээний үндсэн дээр зохион байгуулна.

46.2. Дуудлага худалдааны анхны үнийг Иргэний хуулийн 177.1-д заасны дагуу тогтооно.

46.3. Дуудлага худалдааг Иргэний хуулийн 197 дугаар зүйлийг баримтлан нээлттэй зохион байгуулна.

46.4. Иргэний хуулийн 197.20-д заасан тэмдэглэл, мөн хуулийн 197.23-т заасан гэрээ нь шинэ өмчлөгчийг улсын бүртгэлд бүртгэх үндэслэл болно.

46.5. Дараахь тохиолдолд дуудлага худалдаа болоогүй гэж үзнэ:

46.5.1. өрсөлдөөн гараагүй;

46.5.2. ялагч нь өөрийн санал болгосон үнийг гэрээнд заасан хугацаанд зохих дансанд оруулаагүй.

46.6. Энэ хуулийн 46.5-д заасан тохиолдол бий болсон бол ажлын хоёр өдөрт багтаан дуудлага худалдаа болоогүй тухай мэдээллийг анхны зар нийтлэгдсэн хэвлэлд нийтлүүлнэ.

46.7. Барьцаалагч нь дуудлага худалдаа болоогүй гэж зарласнаас хойш 10 хоногийн дотор барьцаалуулагчтай тохиролцож гэрээ байгуулан барьцааны зүйлийг дуудлага худалдааны анхны үнээр өөрийн өмчлөлд шилжүүлэн авах эрхтэй.

46.8. Энэ хуулийн 46.7-д заасан тохиролцоонд хүрч чадаагүй бол анхны дуудлага худалдаа явуулснаас хойш нэг сараас илүүгүй хугацааны дотор дуудлага худалдааг дахин явуулна.

46.9. Энэ хуулийн 46.5.1-д заасан үндэслэлээр дуудлага худалдааг дахин явуулбал энэ хуулийн 46.2-т заасан үнийг 20 хүртэл хувиар бууруулна.

46.10. Энэ хуулийн 46.5.2-т заасан үндэслэлээр дуудлага худалдааг дахин явуулах анхны үнийг энэ хуулийн 46.2-т зааснаар тогтооно.

46.11. Дуудлага худалдааг дахин явуулахад энэ хуулийн 46.3-т заасныг баримтална.

46.12. Энэ хуулийн 46.9, 46.10-т заасан

дуудлага худалдаа амжилтгүй болсон бол барьцаалагч нь энэ хуулийн 46.2-т заасан үнийн 40 хувиас илүүгүй үнээр барьцааны зүйлийг авах эрхтэй.

46.13. Энэ хуулийн 46.3, 46.7, 46.8, 46.12-т зааснаар барьцааны зүйлийг худалдах буюу барьцаалагч өөрийн шаардлагад тооцон авахдаа Иргэний хуулийн худалдах-худалдан авах гэрээний журмыг баримтална.

46.14. Энэ хуулийн 46.13-т заасны дагуу барьцааны зүйлийг худалдсан буюу өөрийн шаардлагад тооцон авсан, эсхүл барьцаалагч нь энэ хуулийн 46.12-т заасан эрхээ хэрэгжүүлээгүй бол барьцааны эрх дуусгавар болно.

47 дугаар зүйл. Барьцааны зүйлийг шүүхийн журмаар худалдах

47.1. Шүүх барьцааны зүйлийг худалдах тухай үүрэг гүйцэтгүүлэгчийн нэхэмжлэлийг хангасан бол уг зүйлийг Иргэний хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд³ заасан журмын дагуу албадан дуудлага худалдаагаар худалдана.

48 дугаар зүйл. Барьцаалуулагч болон гуравдагч этгээдийн эрх

48.1. Барьцаалуулагч, түүнчлэн тухайн барьцааны зүйлийг өмчлөх эрхтэй холбоотой эрхээ улсын бүртгэлд бүртгүүлсэн гуравдагч этгээд нь барьцаалагч энэ хуулийн 46.7, 46.12-т заасан эрхээ хэрэгжүүлж эхлэхээс өмнө хэдийд ч, гэхдээ барьцааны зүйлийг дуудлага худалдаагаар, эсхүл шууд худалдаагаар товлосон өдрөөс өмнө барьцаалагчийн шаардлагыг хангах замаар барьцааны зүйлийг худалдах ажиллагааг зогсоох эрхтэй.

48.2. Энэ хуулийн 48.1-д заасан журмын дагуу барьцаалагчид төлбөрийг төлж Барьцааны зүйлийг худалдах ажиллагааг зогсоосон гуравдагч этгээдэд түүний гүйцэтгэсэн үүргийн хэмжээгээр барьцаалуулагчийн эрх шилжинэ.

48.3. Энэ хуулийн 48.1-д заасан эрхээ дараалсан 12 сарын хугацаанд нэг удаа, эзэлийн нийт хугацааны туршид хоёр удаа хэрэгжүүлж болно.

49 дүгээр зүйл. Барьцаалагчийн зардлыг нөхөн төлөх

49.1. Энэ хуулийн 48.2-т заасны дагуу эрх шилжүүлэн авсан этгээд нь тухайн шаардлагыг хангахад гарсан зардлыг барьцаалагчид нөхөн төлөх үүрэгтэй.

50 дугаар зүйл. Барьцааны зүйл шинэ өмчлөгчид шилжсэнийг бүртгэх

50.1. Барьцааны зүйлийг үүрэг гүйцэтгүүлэгч шилжүүлэн авсан, эсхүл түүнийг дуудлага худалдаагаар худалдсан бол барьцаалагч нь барьцааны зүйлийг шилжүүлсэн тухай баримт бичгийг улсын бүртгэлд бүртгүүлэх бөгөөд мэдүүлэгт барьцаалагч, барьцаалуулагчийн нэр, хаяг, барьцааны зүйлийн хаяг, барьцааны зүйл нь газар бол кадастрын мэдээлэл, мөн худалдах ажиллагааг энэ хуулийн дагуу явуулсныг тэмдэглэнэ.

51 дүгээр зүйл. Барьцаалагчийн болон гуравдагч этгээдийн эрх дуусгавар болох

51.1. Барьцаалуулагч энэ хуулийн 45.1-д заасны дагуу худалдах-худалдан авах гэрээ байгуулсан, эсхүл тухайн барьцааны зүйлийг шүүхийн журмаар болон шүүхээс гадуур дуудлага худалдаагаар худалдсан, энэ хуулийн 50 дугаар зүйлд заасан бүртгэл хийснээр барьцааны гэрээ, барьцааны зүйлийн тухайд барьцаалагчийн эдлэх бүх эрх, барьцааны гэрээ байгуулснаас хойш барьцааны зүйлийн тухайд үүсч бүртгүүлсэн гуравдагч этгээдийн бүх эрх дуусгавар болно.

51.2. Барьцааны гэрээ байгуулахаас өмнө улсын бүртгэлд бүртгүүлсэн барьцааны зүйлтэй холбоотой эрх хангагдаагүй, эсхүл худалдах-худалдан авах гэрээгээр барьцааны эрх дуусгавар болоогүй бол барьцаалагчийн эрх хэвээр үлдэнэ.

52 дугаар зүйл. Барьцааны зүйлийг худалдсанаас олсон орлогыг хуваарлах

52.1. Барьцааны зүйлийг шүүхээс гадуур худалдсаны орлогыг Иргэний хуулийн 179 дүгээр зүйл, шүүхийн журмаар худалдсаны орлогыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу тус тус хуваарилна.

52.2. Худалдахад гарсан зардлыг суутган авсны дараа барьцаалагчийн энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан шаардлагыг Иргэний хуулийн 216 дугаар зүйлд заасны дагуу хангаж, үлдсэн мөнгөн хөрөнгийг барьцаалуулагчид олгоно.

52.3. Энэ хуулийн 52.1-д заасан хуваарилалтыг дараахь эрх бүхий этгээд хийнэ:

52.3.1. барьцааны зүйлийг шүүхийн журмаар худалдсан бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага;

52.3.2. энэ хуулийн 46.1-д заасан төхил-долд дуудлага худалдаа зохион байгуулагч.

52.4. Барьцааны зүйл нь төрийн болон орон нутгийн өмч бол түүнийг худалдсаны орлогоос эхний ээлжинд холбогдох шаардлагыг хангаж, үлдсэн хэсгийг нь зохих төсөвт оруулна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ГАЗАР БАРЬЦААЛАХ ОНЦЛОГ

53 дугаар зүйл. Газар барьцаалах

53.1. Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газар болон газар эзэмших эрх барьцааны зүйл байж болох бөгөөд түүнийг хуульд заасан нөхцөлөөр барьцаалж болно.

53.2. Хэрэв тухайн газрын түрээсийн болон бусад эд хөрөнгийн эрхийг гэрээгээр иргэн буюу хуулийн этгээдэд шилжүүлсэн бол уул эрхийг олж авсан этгээд нь газар өмчлөгчийн зөвшөөрөлтэйгээр тухайн эрхийн хугацааны дотор барьцаалж болно.

53.3. Газар барьцаалах гэрээнд тухайн газрын кадастрын зураг, газар өмчлөх, ашиглах, эзэмших эрхийн бичгийн хуулбарыг хавсаргана.

54 дүгээр зүйл. Зориулалтын зээлийн хөрөнгөөр олж авсан газрын барьцаа

54.1. Хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдийн зориулалтын зээлийн хөрөнгөөр олж

³ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль - Төрийн мэдээлэл эмтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

авсан газрын хувьд эзэлдэгчийн өмчлөх эрхийг улсын бүртгэлд бүртгэснээр барьцааны эрх үүсэх бөгөөд энэ тохиолдолд банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь барьцаалагч байна.

55 дугаар зүйл. Барьцаалуулагчийн өмчлөлд байгаа барилга байгууламжийн дэвсгэр газрыг барьцаалах

55.1. Барьцааны гэрээнд өөрөөр заагаагүй бол газар барьцаалах эрх нь тухайн газар дээр байгаа болон баригдаж байгаа барьцаалуулагчийн болон гуравдагч этгээдийн өмчлөлийн барилга байгууламжид хамаарахгүй.

55.2. Барьцааны зүйл болох газраас шаардлагыг хангуулсан тохиолдолд уг газрын барьцаалагдаагүй үлдсэн хэсэгт байгаа болон баригдаж байгаа барилга байгууламжийн өмчлөгч буюу эзэмшигч нь өөрийн газар, барилга байгууламжийг зориулалтын дагуу ашиглахад шаардлагатай газрын хэсгийг Иргэний хуулийн 151 дүгээр зүйлд зааснаар хязгаартай ашиглах эрхтэй байна.

55.3. Энэ хуулийн 55.2-т заасан газрын хэсгийг хязгаартай ашиглах нөхцөлийг барьцаалуулагч, барилга байгууламж өмчлөгчийн хооронд байгуулсан гэрээгээр тодорхойлох бөгөөд үүссэн маргааныг шүүх шийдвэрлэнэ.

55.4. Газар барьцаалуулагч нь барьцаалсан газар дээр байгаа бөгөөд энэ хуулийн 55.1-д зааснаар барьцааны эрх үүсгээгүй, өөрийн өмчлөлд байгаа барилга байгууламжийг барьцаалагчийн зөвшөөрөлгүйгээр захиран зарцуулах эрхтэй боловч барьцаалагч нь тухайн барилга байгууламжийн дэвсгэр газрыг бусад худалдан авагчтай ижил нөхцөлөөр тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхтэй.

55.5. Хөдөө аж ахуйн зориулалттай газрыг тухайн газар дээрх барьцаалуулагчийн өмчлөлд байгаа барилга байгууламж зэрэг салгах үл болох бүрдэл хэсгийг хамтад нь барьцаалсан тохиолдолд уг барьцааг хүчинтэйд тооцно.

56 дугаар зүйл. Барьцаалуулагч барьцаалуулсан газар дээр барилга байгууламж барих

56.1. Барьцаалуулагч нь газар барьцаалах гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр барьцаалуулсан газар дээр барилга байгууламж барих эрхтэй бөгөөд барьцааны гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцаа нь тухайн барилга байгууламжид үл хамаарна.

56.2. Барьцаалуулагч барьцаалуулсан газар дээр барилга байгууламж барьсан нь энэхүү газрын барьцаагаар барьцаалагчид олгосон баталгааг дордуулсан буюу дордуулахаар байвал барьцаалагч нь барьцааны гэрээг өөрчлөх, эсхүл тухайн барилга байгууламжийг барьцаандаа хамааруулахыг шаарддаг эрхтэй.

57 дугаар зүйл. Гуравдагч этгээдийн өмчлөлд байгаа барилга байгууламжийн доорх газрын барьцаа

57.1. Барьцааны зүйл болох газрыг барьцаалагч өмчлөлдөө шилжүүлсэн, худалдсан

бол тухайн газар дээр байгаа гуравдагч этгээдийн өмчийн барилга байгууламжийн тухайд уг газрын шинэ өмчлөгчид барьцаалуулагчийн газар өмчлөгч байсантай холбогдсон эрх, үүрэг шилжинэ.

58 дугаар зүйл. Барьцааны зүйл болох газрыг худалдах онцлог

58.1. Барьцааны зүйл болох газрыг албадан дуудлага худалдаагаар худалдах ажиллагаанд зөвхөн Монгол Улсын иргэн оролцоно.

58.2. Барьцааны зүйл болох хөдөө аж ахуйн зориулалт бүхий газрыг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах, дахин боловсруулах, худалдахад зайлшгүй шаардлагатай хугацаат цуврал ээлэн үе шатыг дуусахаас өмнө шилжүүлэх буюу худалдахаар шаардаж болохгүй бөгөөд барьцаагаар хангагдах үүргийг буюу түүний зохих хэсгийг гүйцэтгэхээр тогтоосон оны 11 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл гэрээ хүчинтэй байна.

58.3. Барьцааны зүйлийг худалдах хугацааг хойшлуулсан нь барьцаагаар хангагдах үүргийн талуудын эрх, үүрэгт нөлөөлөхгүй бөгөөд хойшлуулсан хугацаанд барьцаалагчид учирсан хохирол, хүү, анзгыг нөхөн төлөх үүргээс үүрэг гүйцэтгэгч чөлөөлөгдөхгүй.

58.4. Үүрэг гүйцэтгэгч нь хойшлуулсан хугацааны дотор үүрэг гүйцэтгүүлэгчийн барьцаагаар хангагдах шаардлагыг бүрэн хангасан бол шүүх барьцааг хангах талаар урьд гаргасан шийдвэрээ үүрэг гүйцэтгэгчийн өргөдлөөр хүчингүй болгоно.

58.5. Шүүх дараахь үндэслэл байвал барьцаалсан газрыг худалдах хугацааг хойшлуулж болохгүй:

58.5.1. худалдахыг хойшлуулах нь барьцаалагчийн санхүүгийн байдлыг ноцтой хүчдрүүлэхээр байвал;

58.5.2. барьцаалагчийг төлбөрийн чадваргүйд тооцуулахаар дампуурлын эрэг үүсгэсэн бол.

АРАВДУГААР БҮЛЭГ

ОРОН СУУЦ БАРЬЦААЛАХ ОНЦЛОГ

59 дүгээр зүйл. Нийтийн зориулалттай орон сууцны байшин дахь сууцны барьцаалах

59.1. Нийтийн зориулалттай орон сууцны байшин дахь хэсгээр өмчлөх дундын өмчлөлд байгаа сууцны барьцаалуулахад тухайн сууцнаас гадна хамтран өмчлөх дундын өмчийн эрхийн дагуу уг барьцаалуулагчид оногдох хэсгийг хамтад нь барьцаалуулсан гэж үзнэ.

60 дугаар зүйл. Зориулалтын зээлийн хөрөнгөөр олж авсан орон сууцны байшин, сууцныг барьцаалах

60.1. Хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдийн зориулалтын зээлийн хөрөнгөөр олж авсан, барьсан орон сууцны байшин, сууцны өмчлөх эзэлдэгчийн эрхийг улсын бүртгэлд бүртгэснээр барьцааны эрх үүсэх бөгөөд энэ тохиолдолд банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх

эрх бүхий хуулийн этгээд нь барьцаалагч байна.

61 дүгээр зүйл. Шаардах эрхийг хангах

61.1. Барьцааны зүйл болох орон сууцнаас үүргийн гүйцэтгэлийг хангуулах шаардлагыг энэ хуулийн наймдугаар бүлэгт заасны дагуу шүүхийн журмаар, эсхүл талууд харилцан тохиролцож шүүхээс гадуур шийдвэрлэнэ.

61.2. Барьцааны зүйлээс үүргийн гүйцэтгэлийг хангуулж орон сууцыг худалдсан бол тухайн орон сууцыг хуульд заасан журмаар чөлөөлнө.

61.3. Шаардлага хангах үед хүчинтэй байсан орон сууц хөлслөх гэрээ уг орон сууцыг худалдсаны дараа хүчин төгөлдөр хэвээр байна.

62 дугаар зүйл. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах

62.1. Үл хөдлөх эд хөрөнгө худалдан авах, барилга байгууламж, орон сууц барих, засан сайжруулах зорилгоор тухайн үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалж зээл авах гэрээ байгуулахаас өмнө барьцаалагч нь барьцаалуулагчид дараахь мэдээллийг бичгээр өгч, тайлбарлах үүрэгтэй:

62.1.1. барьцаалагч, түүнийг төлөөлөх этгээдийн нэр, хаяг;

62.1.2 зээлийн зориулалт;

62.1.3. зээлийг буцаан төлөх хугацаа, төлбөрийн хэмжээ, хэсэгчлэн төлөх бол ийнхүү хэсэгчлэн төлөх хугацаа, хэмжээ, зээлийн үндсэн өр болон хүүгийн хуваарилалт, төлөх газар, төлбөр хийх арга;

62.1.4. хувьсах хүүтэй зээлийн

хувьд зээлийн хүүгийн өөрчлөлтийг тодорхойлох томъёо, өөрчлөлтийн давтамж;

62.1.5. хууль болон гэрээнд заасны дагуу зээлдэгчийн төлбөл зохих зээлтэй холбоотой давтгалын, нотариатын болон бүртгэлийн хураамж, бусад зардал;

62.1.6. зээлдэгч зээлийн үндсэн өр болон түүний хүүг бүхэлд нь буюу тэдгээрийн хэсгийг урьдчилан төлөх боломжтой эсэх, хэрэв боломжтой бол ийнхүү урьдчилан төлөхтэй холбоотой нөхцөл;

62.1.7. зээлийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд барьцааны зүйлийг алдаж болох тухай болон тухайн эд хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулах үе шаттай арга хэмжээ;

62.1.8. барьцааны гэрээний нөхцөл, барьцааны зүйлийг ашиглах, захиран зарцуулах талаар тавих хязгаарлалт, эд хөрөнгийг хадгалж хамгаалах, гэрээнд заасан бол даатгуулах үүрэг;

62.1.9. барьцааны зүйлийг үнэлүүлэх шаардлагатай эсэх, хэрэв шаардлагатай бол үнэлгээ хийх этгээд.

62.2. Энэ хуулийн 62.1-д заасан мэдээллийг өгөх журам, маягтыг Монголбанк (Төвбанк), Санхүүгийн зохицуулах хороо батлах бөгөөд уг журмыг зөрчсөн бол мэдээлэл өгөөгүй гэж үзнэ.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН БАРЬЦААНЫ
ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд заасан журмыг уг хуулийг хүчин төгөлдөр болсноос хойш үүссэн үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбогдсон харилцаанд хэрэглэнэ.

2 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбогдсон харилцаа нь Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө үүссэн боловч талуудын эрх, үүрэг

нь уг хуулийг хүчин төгөлдөр болсны дараа үүссэн бол тэдгээр эрх, үүрэгт мөн хуулийг хэрэглэнэ.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

**ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Иргэний хуулийн 176 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 176.2.3 дахь заалт нэмсүгэй:

"176.2.3. хуульд заасан бусад үндэслэл."

2 дугаар зүйл. Иргэний хуулийн 153 дугаар зүйлийн 153.1 дэх хэсэг, 175 дугаар зүйлийн 175.1 дэх хэсгийн "гүйцэтгээгүй" гэсний дараа "буюу зохих ёсоор гүйцэтгээгүй" гэж, 156 дугаар зүйлийн 156.4 дэх хэсгийн "хүсвэл" гэсний дараа "үл хөдлөх эд

хөрөнгийн барьцааны гэрээг нотариатаар гэрчлүүлэх," гэж, 169 дүгээр зүйлийн 169.1 дэх хэсгийн "үеэс" гэсний дараа "буюу хуульд заасан бусад тохиолдолд" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн 177.1 дэх хэсгийн "шинжээчийн" гэснийг "хараат бус, мэргэжлийн үнэлгээчийн" гэж, "Шинжээчийг" гэснийг "Хараат бус мэргэжлийн үнэлгээчийг" гэж тус тус өөрчилсүгэй.



4 дүгээр зүйл. Иргэний хуулийн 156 дугаар зүйлийн 156.2 дахь хэсгийн "нотариатаар гэрчлүүлж" гэснийг, 172 дугаар зүйлийн 172.2 дахь хэсгийн "нотариатаар гэрчлүүлсэн" гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Иргэний хуулийн 165 дугаар зүйлийн 165.2 дахь хэсэг, 174 дүгээр зүйлийн 174.2

дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.
6 дугаар зүйл. Энэ хуулийг Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

ДДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

ЭД ХӨРӨНГӨ ӨМЧЛӨХ ЭРХ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ЭД ХӨРӨНГИЙН БУСАД ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг нэмсүгэй:

1/28¹ дүгээр зүйл:

"28¹ дүгээр зүйл. Ипотекийг бүртгэхээс татгалзах буюу хойшлуулах

28¹.1. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуульд заасан үндэслэл байвал ипотекийг бүртгэхээс татгалзах эрхтэй.

28¹.2. Дараахь тохиолдолд ипотекийн бүртгэлийг 1 сараас илүүгүй хугацаагаар хойшлуулж болно:

28¹.2.1. энэ хуулийн 28.2, 28.7-д заасан аль нэг баримт бичгийг бүртгэх байгууллагад ирүүлээгүй;

28¹.2.2. гэрээ, барьцаалбар, тэдгээрийн хавсралт нь хууль тогтоомжид заасан шаардлагад нийцээгүй;

28¹.2.3. ирүүлсэн баримт бичиг нь хуурамч эсэхийг шалгах үндэслэл байгаа бол.

28¹.3. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь ипотекийн бүртгэлийг хойшлуулах тухай шийдвэр гаргахдаа шаардагдах баримт бичгийг ирүүлэх буюу илэрсэн эерчлийг арилгахыг шаардах бөгөөд тогтоосон хугацаанд шаардлагыг биелүүлээгүй бол ипотекийг бүртгэхээс татгалзана.

28¹.4. Барьцааны зүйл болох эд хөрөнгийн эрхийн талаар болон түүнийг гүйцлээнд оруулсан тухай маргааныг шүүх хянаж байгаа бол түүнийг шийдвэрлэх хүртэл улсын бүртгэлд бүртгэхийг хойшлуулна.

28¹.5. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь ипотекийг бүртгэхээс татгалзсан үндэслэлээ мэдүүлэгт тэмдэглэж хуульд заасан хугацааны дотор барьцаалагч, барьцаалуулагч нарт мэдүүлэг болон хавсралт баримт бичгийг буцаана."

2/ 28² дугаар зүйл:

"28² дугаар зүйл. Ипотекийн бүртгэлийг нотлох

28².1. Барьцааны эрхийн улсын бүртгэлийн тэмдэглэлд доорх мэдээллийг тусгана:

28².1.1. анхны барьцаалагч;

28².1.2. барьцааны зүйл;

28².1.3. барьцаагаар хангагдах

шаардлагын хэмжээ, эсхүл уг хэмжээг тодорхойлох журам.

28².2. Гэрээнд барьцаалагчийн эрхийг барьцаалбараар гэрчлэхээр заасан бол энэ тухай тэмдэглэлд тусгана.

28².3. Барьцааг эрхийн улсын бүртгэлд бүртгэхдээ барьцааны гэрээнд, хэрэв барьцааны эрх хуулиар үүссэн бол барьцаагаар үүрэг хүлээсэн барьцаалуулагч нь өмчлөгч болохыг нотолсон баримт бичигт тус тус бичилт хийх бөгөөд уг бичээст эрхийн улсын бүртгэлд бүртгэсэн бүртгэх байгууллагын бүтэн нэр, бүртгэсэн он, сар, өдөр, газар, бүртгэлийн дугаарыг тусгаж эрхийн улсын бүртгэл хийж байгаа албан тушаалтан гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарна.

28².4. Барьцаа нь гэрээгээр үүссэн бол ийнхүү гэрээний хуулбарыг, хуулиар үүссэн бол ийнхүү барьцаа үүссэнийг нотлох баримт бичгийг хавсаргана."

3/29 дүгээр зүйлийн 29.5-29.7 дахь хэсэг:

"29.5. Хэд хэдэн ипотека нэг этгээдээс өөр этгээдэд зэрэг шилжээнийг бүртгүүлэх тухай мэдүүлийг түүнийг шилжүүлэн авч байгаа этгээд гаргана.

29.6. Хэд хэдэн ипотека нэг этгээдээс өөр этгээдэд зэрэг шилжээнийг бүртгүүлэхдээ нэг мэдүүлэг гаргах бөгөөд мэдүүлэгт ийнхүү шилжүүлснийг нотлох гэрээг хавсаргана.

29.7. Барьцааны эрх нь барьцаалбараар гэрчлэгдэж байгаа бөгөөд талууд барьцаалбарыг бүртгүүлэхээр тохиролцоогүй бол энэ хуулийн 29.5, 29.6-д заасан журам хамаарахгүй."

4/ 31¹ дүгээр зүйл:

"31¹ дүгээр зүйл. Барьцааны эрх дуусгавар болсныг бүртгэх

31¹.1. Барьцаалбарын хууль ёсны эзэмшигч, эсхүл барьцаалагч, барьцаалуулагч хамтран гаргасан хүсэлт, түүнчлэн шүүх, арбитрын шийдвэрийг үндэслэн барьцааг дуусгавар болгоно.

31¹.2. Барьцаагаар хангагдах үүргийг бүрэн гүйцэтгэсэн хойш 30 хоногийн дотор барьцаалагч нь барьцааны гэрээг дуусгавар болгохыг зөвшөөрсөн бичгийг барьцаалуулагчид өгнө.

31¹.3. Барьцааны эрх дуусгавар болсныг эрхийн улсын бүртгэлд бүртгэсэн барьцаалбараар гэрчлэгдсэн эрх дуусгавар болно.

31¹.4. Энэ хуулийн 31¹.3-т заасан тохиолдолд барьцаалбарыг барьцаалуулагчид

түүний шаардсанаар шилжүүлнэ.”

5/ 31² дугаар зүйл:

“31² дугаар зүйл. Ипотекийн бүртгэлтэй холбоотой нэхэмжлэл гаргах

31^{2.1}. Дор дурдсан тохиолдолд улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаар сонирхогч этгээд захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй:

31^{2.1.1}. барьцааг эрхийн улсын бүртгэлд бүртгэхээс хууль бусаар татгалзсан буюу зайлсхийсэн;

31^{2.1.2}. барьцаалбарыг анхны барьцаа-лагчид олгохоос хууль бусаар татгалзсан; 31^{2.1.3}. ипотекийн бүртгэлд засвар, нэмэлт, өөрчлөлт оруулахаас хууль бусаар татгалзсан;

31^{2.1.4}. тогтоосон журмыг зөрчиж барьцааны эрх дуусгавар болсон тухай бүртгэл хийсэн;

31^{2.1.5}. барьцааны зүйл байхгүй байхад барьцааны гэрээг бүртгэсэн;

31^{2.1.6}. улсын бүртгэлийн байгууллагын хуульд нийцээгүй бусад үйлдлийн талаар.”

6/ 31³ дугаар зүйл:

“31³ дугаар зүйл. Улсын бүртгэлийн байгууллагын хүлээх хариуцлага

31^{3.1}. Ипотекийг бүртгэсэн болон бүртгэх үүрэгтэй байгууллага дор дурдсан хууль бус үйлдэл буюу эс үйлдэхгүйгээр учруулсан хохирлыг арилгах үүрэгтэй:

31^{3.1.1}. ипотекийг улсын бүртгэлд бүртгэхээс үндэслэлгүйгээр татгалзсан;

31^{3.1.2}. улсын бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулахаас үндэслэлгүйгээр татгалзсан;

31^{3.1.3}. улсын бүртгэлд бүртгэх хуулиар тогтоосон хугацааг үндэслэлгүйгээр хойшлуулсан буюу хэтрүүлэн саатуулсан;

31^{3.1.4}. улсын бүртгэлийн тэмдэглэлд хуульд зааснаар тусгавал зохих шаардлагыг хангаагүй, эсхүл өөр бусад алдаа гаргасан;

31^{3.1.5}. анхны буюу шинээр үйлдсэн барьцаалбар олгоогүй;

31^{3.1.6}. бүртгэлийг хууль бусаар хаасан;

31^{3.1.7}. хуурамч бүртгэл хийсэн болон хуульд заасан бусад үндэслэл байвал.”

2 дугаар зүйл. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Иргэний хууль,” гэсний дараа “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“28 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны бүртгэл

28.1. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа / цаашид “ипотек” гэх/-г бүртгүүлэх тухай мэдүүлгийг өмчлөгч гаргах ба улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мэдүүлгийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн

дотор улсын бүртгэлд бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ. 28.2. Гэрээгээр үүссэн барьцааг барьцаалагч, барьцаалуулагчийн хамтарсан мэдүүлгээр бүртгэх ба уг мэдүүлэгт дараахь баримт бичгийг хавсаргана:

28.2.1. барьцааны гэрээ болон түүний хуулбар;

28.2.2. барьцааны гэрээнд зааж хавсралт болгосон баримт бичиг;

28.2.3. үйлчилгээний хураамж төлсөн баримт.

28.3. Хуульд заасан үндэслэлээр үүссэн барьцаалах эрхийг улсын бүртгэлд бүртгэхэд тусгайлан мэдүүлэг шаардахгүй бөгөөд үйлчилгээний хураамж төлөхгүй.

28.4. Энэ хуулийн 28.2-т заасан эрхийн улсын бүртгэлийг уг барьцаагаар үүрэгжсэн өмчлөх эрхийн бүртгэлтэй нэгэн зэрэг хийнэ.

28.5. Энэ хуулийн 28.2-т заасан эрхийг барьцаалбараар гэрчлэн нотолж болно.

28.6. Барьцаалагчийн эрхийг барьцаал-бараар гэрчилсэн бол барьцааг бүртгүүлэхэд энэ хуулийн 28.2.1-28.2.3-т зааснаас гадна дараахь баримт бичгийг хавсаргана:

28.6.1. барьцааг эрхийн улсын бүртгэлд бүртгэсэн тухай лавлагаанаас бусад барьцаалбар, түүний хуулбар;

28.6.2. барьцаалбарт хавсаргасан баримт бичиг, түүний хуулбар.

28.7. Үндсэн үүрэг буюу гэрээгээр үүссэн эрхийг шилжүүлсний улмаас барьцаалагч солигдсон бол өмнөх болон шинэ барьцаалагчийн хамтарсан мэдүүлгийг үндэслэн ипотекийг эрхийн улсын бүртгэлд бүртгэнэ.

28.8. Барьцааг бүртгэх дараалал нь улсын бүртгэлийн байгууллага мэдүүлгийг зохих баримт бичгийн хамт хүлээн авсан он, сар, өдрөөр тодорхойлогдоно.

28.9. Гуравдагч этгээдийн хувьд хүлээж авсан барьцааг эрхийн улсын бүртгэлд бүртгэсэн үеэс барьцааны эрх үүссэн гэж үзнэ.

28.10. Төрийн өөрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн ипотекийг бүртгүүлэх мэдүүлэгт төрийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагын зөвшөөрлийг хавсаргана.”

4 дүгээр зүйл. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.5 дахь заалтын “Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын” гэснийг “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны” гэж өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хууль” гэснийг, 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

БАНК, ЭРХ БҮХИЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МӨНГӨН ХАДГАЛАМЖ, ТӨЛБӨР ТООЦОО, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 29 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 5, 6 дахь хэсэг нэмсүгэй:

"5. Иргэн, хуулийн этгээдэд олгох зээлийн гэрээний үүргийг баталгаажуулж үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ байгуулсан тохиолдолд зээлдэгч Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд заасан журмаар барьцаалбар үйлдэж болно.

6. Үүргийн гүйцэтгэлийг барьцаалбараар гэрчилсэн тохиолдолд барьцааны зүйлийг хуульд заасны дагуу шүүхээс гадуур худалдаж болно."

2 дугаар зүйл. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо,

зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 2 дугаар зүйлийн "Банкны хууль," гэсний дараа "Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль," гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 5, 6 дахь хэсгийн дугаарыг "7, 8" болгон өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 7.1.11 дэх заалт нэмсүгэй:

"7.1.11. Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

ИПОТЕКИЙН ЗҮЙЛИЙГ ШҮҮХИЙН БУС ЖУРМААР ХУДАЛДАН БОРЛУУЛАХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2005 оны 7 дугаар сарын 07-ны өдөр баталсан Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын "өмчийг" гэсний дараа, 77 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "шилжүүлэх," гэсний дараа "барьцаалах," гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 35.1.7 дахь заалт нэмсүгэй:

"35.1.7.газар эзэмших эрхээ энэ хуульд заасан журмын дагуу барьцаалах."

2 дугаар зүйл. Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5 дахь хэсгийн "эрхийн гэрчилгээгээ" гэснийг "газар эзэмших эрхээ" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Газрын тухай хуулийн 35.1.4 дэх заалтын "барьцаалах", 38.5 дахь хэсгийн "Энэ хуулийн 35.1.4-т заасан зөвшөөрөлтэйгөөр" гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

ХОХИРОГЧИД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр нийслэлийн Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт гарсан нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самууны үеэр амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсон иргэн, цагдаа, дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагын албан хаагч /цаашид "төрийн тусгай албан хаагч" гэх/, хуулийн этгээдэд нөхөх олговор олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хохирогчид нөхөх олговор олгох тухай хууль тогтоомж

2.1. Хохирогчид нөхөх олговор олгох тухай хууль тогтоомж нь Эрүүгийн хууль¹, Иргэний хууль², Эрүүгийн байцаан шийтгэх хууль³, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль⁴, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль⁵, энэ хууль болон

эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хууль нь мөн хуулийн 1 дүгээр зүйлд заасан нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самууны үеэр амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсон иргэн, төрийн тусгай албан хаагч, хуулийн этгээд /цаашид "хохирогч" гэх/-д хамаарна.

3.2. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самуунд оролцож, шүүхийн шийтгэх тогтоолоор ял шийтгүүлсэн гэм буруутай этгээдэд мөн хуульд заасан нөхөх олговрыг олгохгүй.

4 дүгээр зүйл. Нөхөх олговрын хэмжээ

4.1. Дараахь хохирогчид дор дурдсан хэмжээгээр төрөөс нэг удаа нөхөх олговор олгоно:

4.1.1. амь насаа алдсан иргэний ар гэрт тус бүр 50 сая төгрөгийн;

¹ Эрүүгийн хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 5 дугаарт нийтлэгдсэн.

² Иргэний хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

³ Эрүүгийн байцаан шийтгэх хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.



4.1.2. албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэндээрээ хохирсон төрийн тусгай албан хаагчид шүүх эмнэлгийн шинжилгээгээр

тогтоогдсон гэмтлийн зэргийг нь харгалзан тухайн албан хаагчийн албан тушаалын нэг сарын цалинг дор дурдсан хэмжээгээр өсгөж:

Д/д	Гэмтлийн зэрэг	Албан тушаалын нэг сарын цалинг өсгөх хэмжээ /дахинаар/
1	Хүнд	36
2	Хүндэвтэр	12
3	Хөнгөн	3

4.1.3. эрүүл мэндээрээ хохирсон иргэнд шүүх эмнэлгийн шинжилгээгээр тогтоогдсон

гэмтлийн зэргийг нь харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дор дурдсан хэмжээгээр өсгөж:

Д/д	Гэмтлийн зэрэг	Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг өсгөх хэмжээ /дахинаар/
1	Хүнд	112
2	Хүндэвтэр	37
3	Хөнгөн	9

4.1.4. эд хөрөнгөд нь хохирол учирсан хохирогчид Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу гарсан шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бодит хохирлын хэмжээгээр.

4.2. Энэ хуулийн 4.1.1-4.1.3-т заасан хохирогчийн нэхэмжилсэн эдийн бус хохиролд Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу гарсан шүүхийн шийдвэрээр тогтоогдсон хохирлын хэмжээгээр нөхөх олговрыг олгоно.

5 дугаар зүйл. Нөхөх олговрын эх үүсвэр

5.1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан нөхөх олговрыг улсын төсвөөс олгоно.

6 дугаар зүйл. Нөхөх олговор олгох журм

6.1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан нөхөх олговор олгох журмыг Засгийн газар батална.

6.2. Энэ хуулийн 4.1.2-т заасан төрийн тусгай албан хаагчид урьд нь улсын болон орон нутгийн төсвөөс нөхөх олговор олгосон, эсхүл тусламж үзүүлсэн бол тэдгээрийг энэ хуулийн дагуу олговол

зохиж нөхөх олговрын нийт дүнд оруулж тооцно.

6.3. Даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу нөхөн төлбөр авах эрх бүхий энэ хуулийн 4.1.4-т заасан хохирогч хохирлоо уг эх үүсвэрээс барагдуулсан буюу барагдуулах боломжтой бол түүнд олгох нөхөх олговрыг мөн хэмжээгээр суутган хасч тооцох бөгөөд даатгалын байгууллага гаргасан даатгалын нөхөн төлбөрөө гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

7 дугаар зүйл. Нөхөх олговрыг буцаан төлүүлэх

7.1. Хохирогчид учирсан хохирлыг энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самуунд оролцож, ял шийтгүүлсэн этгээдийн хувьд ногдох эд хөрөнгөөс гаргуулахаар шүүх шийдвэрлэсэн бол уг төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,ӨӨРЧӨЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 10.1.5 дахь заалт нэмсүгэй.

"10.1.5. хуулийн этгээдийн ажиллах хүчний 90-ээс доошгүй хувь нь Монгол Улсын иргэн байх."

2 дугаар зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан

авах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"9.3. Энэ хуулийн 9.2-т зааснаас бусад тендер шалгаруулалтад гадаадын этгээдийг оролцуулж үл болно."

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА, САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 24.2 дахь хэсэг нэмсүгэй:

"24.2.Төсвийн байгууллагын эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах

ажиллагаанд оролцогч Монгол Улсын хуулийн этгээдийн ажиллах хүчний 90-ээс доошгүй хувь нь Монгол Улсын иргэн байна."

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

ЭХ, ХҮҮХДЭД ТЭТГЭМЖ ОЛГОХ, ХҮҮХЭД, ЭХ, ГЭР БҮЛД МӨНГӨН ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуулийн 6 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 6.4.3 дахь заалт нэмсүгэй:

"6.4.3. нийгмийн даатгалын сангаас жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүсээгүй тухай холбогдох байгууллагын тодорхойлолт."

2 дугаар зүйл. Эх, хүүхдэд тэтгэмж олгох,

хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсгийн 1 дэх өгүүлбэрийн "Эх" гэснийг "Нийгмийн даатгалын сангаас жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүсээгүй эх" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын "шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0,3 хувийн алданги ногдуулна. Энэхүү алдангийн хэмжээ нь төлбөл зохих шимтгэлийн 50 хувиас хэтрэхгүй байна." гэсэн заалтын үйлчлэлийг

2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл түр зогсоосугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2009 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "9" гэснийг "6" гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн "6" гэснийг "3" гэж, 4 дүгээр зүйлийн "76" гэснийг "126" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2009 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь бүлэг, заалт нэмсүгэй:

1/ Наймдугаар бүлэг:

"НАЙМДУГААР БҮЛЭГ.Өвчтөн сахисны тэтгэмж

21² дугаар зүйл. Өвчтөн сахисны тэтгэмж

1. Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг нийтдээ 3-аас доошгүй сар төлсөн даатгуулагч эх / эцэг/, хууль ёсны асран хамгаалагч 0-5 насны хүүхдээ эмнэлэгт сахиж эмчлүүлсэн бол өвчтөн сахисны тэтгэмж олгоно.

2. Даатгуулагчид өвчтөн сахисны тэтгэмжийг хуанлийн жилд нийтдээ ажлын 30 өдрөөс илүүгүй хугацаанд тооцож олгоно.

3. Өвчтөн сахисны тэтгэмжийн хэмжээг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно.

4. Өвчтөн сахисны тэтгэмж тогтоолгох өргөдөл гаргах журам, шийдвэрлэх хугацаа, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална."

2/ 2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт:

"4/ өвчтөн сахисны тэтгэмж."

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн НАЙМДУГААР бүлгийн дугаарыг "ЕСДҮГЭЭР", ЕСДҮГЭЭР бүлгийн дугаарыг "АРАВДУГААР" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2009 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж ажлын байрыг нэмэгдүүлэх, импортыг орлох, экспортыг дэмжсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор импортоор оруулж байгаа жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалтыг "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/-ийн" ангиллын дагуу Засгийн газар батална.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж ажлын байрыг нэмэгдүүлэх, импортыг орлох, экспортыг дэмжсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор импортоор оруулж байгаа жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалтыг "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/-ийн ангиллын дагуу Засгийн газар батална.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар
сарын 09-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨЛБӨР ТООЦООГ ҮНДЭСНИЙ МӨНГӨН ТЭМДЭГТЭЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа, ажил, үйлчилгээний үнийг үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж, төлбөр тооцоог гүйцэтгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль тогтоомж

2.1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Төв банк /Монголбанк/ -ны тухай хууль², Валютын зохицуулалтын тухай хууль³, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "Монгол Улсын нутаг дэвсгэр" гэж эдийн засгийн чөлөөт бус, Монгол Улсад байгаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газрын байршлаас бусад Монгол Улсын газар нутгийг;

3.1.2. "үндэсний мөнгөн тэмдэгт" гэж Монголбанкнаас гүйлгээнд гаргасан төлбөрийн хууль ёсны хэрэгсэл болох төгрөгийг хэлэх бөгөөд төгрөгийг англи хэл дээр "Togrog", товчлолыг "MNT" гэж бичнэ;

3.1.3. "Монголбанкны албан ханш" гэж банк хооронд болон банкнаас байгууллага, иргэнтэй хийсэн гадаад валютын бэлэн бус арилжааны дүн, ханшид үндэслэн тооцоолж Монголбанкнаас зарласан ханшийг;

3.1.4. "гадаад валют" гэж гадаадын мөнгөн тэмдэгт, гадаадын валютыг;

3.1.5. "гадаадын мөнгөн тэмдэгт" гэж Монгол Улсаас бусад улсын эрх бүхий байгууллагаас гүйлгээнд гаргасан төлбөрийн хууль ёсны хэрэгсэл болох гадаад орны мөнгөн тэмдэгтийг;

3.1.6. "гадаадын валют" гэж улс хоорондын худалдаа, эдийн засаг, санхүүгийн харилцааны төлбөрт хэрэглэгдэж байгаа гадаад орны мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдэж, түүгээр төлөгдөх үнэт цаас, төлбөрийн бусад хэрэгслийг;

3.1.7. "тооцооны нэгж" гэж бараа,

ажил, үйлчилгээний үнэ нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханштай уялдан өөрчлөгдөж байхаар илэрхийлсэн үнийн саналыг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ҮНДЭСНИЙ МӨНГӨН ТЭМДЭГТЭЭР ГҮЙЦЭТГЭХ ТӨЛБӨР ТООЦОО

4 дүгээр зүйл. Үндэсний мөнгөн тэмдэгтийн хэрэглээ

4.1. Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба энэ хуулийн 4.4-т зааснаас бусад тохиолдолд Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглоно.

4.2. Улсын болон орон нутгийн төсөвт төлөх, төсвөөс санхүүжүүлэх аливаа төлбөр тооцоог зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх бөгөөд эдгээр төлбөр тооцоог гадаад валютаар гүйцэтгэхийг хориглоно.

4.3. Монгол Улсын хууль тогтоомжид хураамж, шимтгэл, хариуцлагын хэмжээг тодорхойлохдоо зөвхөн төгрөгөөр илэрхийлнэ.

4.4. Банк, банк бус санхүүгийн байгууллагын мөнгөн хадгаламж, зээл, тэдгээртэй адилтгах аливаа үйлчилгээ, санхүүгийн үүсмэл хэрэгслэлтэй холбоотой байгуулах гэрээ, түүгээр хүлээх үүргийг гадаад валютаар илэрхийлж, гүйцэтгэлийг гадаад валютаар хангуулж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ

5 дугаар зүйл. Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих байгууллага

5.1. Банкнд Монголбанкны хянан шалгагч, банкнаас бусад хуулийн этгээд, иргэнд Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч хяналт тавина.

5.2. Энэ хуулийн хэрэгжилтэд Монголбанк, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрийн дагуу хамтарсан хяналт шалгалт хийж болно.

6 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

6.1. Энэ хуулийн 4.1-4.3-т заасныг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгээхээр гүйц бол дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

¹ Монгол Улсын Үндсэн хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

² Төв банк /Монголбанк/-ны тухай хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1996 оны 11 дугаарт нийтлэгдсэн.

³ Валютын зохицуулалтын тухай хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1994 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

6.1.1. зөрчлийг арилгуулах талаар шаардлага тавьж тухайн үйл ажиллагаанаас олсон орлогыг хурааж улсын орлого болгож;

6.1.2. энэ хуулийн 6.1.1-д заасан зөрчлийг арилгаагүй бол зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10–30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50–100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох буюу үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүчингүй болгуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;

6.1.3. тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд зөрчлөө арилгах талаар эрх бүхий

байгууллагаас удаа дараа тавьсан шаардлагыг хэрэгжүүлээгүй бол Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн^{*} 13, 14 дүгээр зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох.

6.2. Шүүх энэ хуулийн 6.1.2-т заасан нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэнэ.

7 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

7.1. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 09-ны өдөр

Улаанбаатар хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хуулийн 218 дугаар зүйлийн 218.2 дахь хэсгийн “Мөнгөн тэмдэгтийн” гэснийг “Хуульд өөрөөр заагаагүй бол мөнгөн тэмдэгтийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төлбөр тооцоог

үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 09-ны өдөр

Улаанбаатар хот

ВАЛЮТЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Валютын зохицуулалтын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 5 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

“6. Валютын арилжаа хийх тусгай зөвшөөрөлтэй банк бус санхүүгийн байгууллага нь валютын захын эрэлт хэрэгцээнд үндэслэн бэлэн валют худалдах, худалдан авах өөрийн ханшийг тогтооно.”

2/ 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6, 7 дахь заалт:

“6/валютын хяналтын улсын байцаагчид шалгуулахаас татгалзсан, шалгалт хийхэд саад учруулсан хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас гуч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож;

7/валютын арилжааны мэдээг ирүүлэхдээ хугацаа хоцроосон, эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу ирүүлээгүй хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож.”

2 дугаар зүйл. Валютын зохицуулалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн “Монголбанк” гэсний дараа “, Санхүүгийн зохицуулах хороо” гэж, 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монголбанкны дэд ерөнхийлөгч” гэсний дараа “, Санхүүгийн зохицуулах хорооны дарга” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “томилно” гэсний өмнө “, Санхүүгийн зохицуулах хорооны валютын хяналтын улсын байцаагчийг Санхүүгийн зохицуулах хорооны дарга тус тус” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Валютын зохицуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“5. Эдийн засгийн харьяат болон харьяат бусын гадаад валютаар олсон орлого, импортын барааны хилийн үнийг төгрөгт шилжүүлэн гаалийн болон бусад татвар ногдуулах хэмжээг тодорхойлох, гадаад валютаар илэрхийлэгдсэн аливаа хөрөнгө, эх үүсвэрийг нягтлан бодох бүртгэлд төгрөгөөр илэрхийлж тусгахад Монголбанкнаас зарласан тухайн өдрийн албан ханшийг баримтална.”

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

* Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль – “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2001 оны 16 дугаарт нийтлэгдсэн

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГОЛ, МӨРНИЙ УРСАЦ БҮРЭЛДЭХ ЭХ, УСНЫ
САН БҮХИЙ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН БҮС,
ОЙН САН БҮХИЙ ГАЗАРТ АШИГТ МАЛТМАЛ
ХАЙХ, АШИГЛАХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох, тухайн газарт байгаль орчныг нийхн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль тогтоомж

2.1. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль тогтоомж нь Монгол Улсын үндсэн хууль¹, үндэсний аюулгүй байдлын тухай², Байгаль орчныг хамгаалах тухай³, Усны тухай⁴, Ойн тухай⁵, Ашигт малтмалын тухай хууль⁶, энэ хууль болон эдгээрэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "гол, мөрний урсац бүрэлдэх эх" гэж гадаргын урсацын үндсэн хэсэг бүрэлдэн бий болдог өндөр уулсын бүс, сав газрын эхийг;

3.1.2. "ойн сан бүхий газар" гэж Ойн тухай хуулийн 3.1.2-т заасныг;

3.1.3. "усны сан бүхий газрын хамгаалалтын бүс" гэж Усны тухай хуулийн 31.3-т заасныг.

4 дүгээр зүйл. Ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох

4.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглоно.

4.2. Энэ хуулийн 4.1 дэх хэсэг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамаарахгүй.

4.3. Энэ хуулийн 4.1-д заасан газрын хилийн заагийг Засгийн газар тогтооно.

4.4. Энэ хуулийн 4.3-т заасан хилийн заагийн гадна үйл ажиллагаа эрхэлж байгаа тусгай

зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн хөрөнгөөр байгаль орчны нөхөн сэргээлт хийж, таримал ой, хиймэл нуур, усан сан байгуулсан бол энэхүү хуулийн үйлчлэлд хамаарахгүй.

4.5. Энэ хуулийн 4.1-д заасан газарт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй.

4.6. Ашигт малтмалын тухай хуулийн 56.1.3-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцлахдаа уг тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговор төлөх бөгөөд холбогдох журмыг Засгийн газар тогтооно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ НӨХӨН СЭРГЭЭХ
АЖИЛЛАГАА**

5 дугаар зүйл. Байгаль орчныг нөхөн сэргээх

5.1. Энэ хуулийн 4.6-д заасны дагуу ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцалсан нь тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийг байгаль орчныг нөхөн сэргээх үүргээс чөлөөлөхгүй.

5.2. Байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг орон нутгийн удирдлага болон нутгийн иргэдийн олон нийтийн хяналт дор 2 хүртэл жилийн хугацаанд хийж дуусгана.

5.3. Энэ хуулийн 5.2-т заасан олон нийтийн хяналтыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр байгаль орчныг хамгаалах зорилго, чиглэл бүхий төрийн бус байгууллагуудад гэрээний үндсэн дээр хариуцуулж болно.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ
БУСАД**

6 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

6.1. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд зөрчлийн шинж байдлыг харгалзан Эрүүгийн хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэж, учирсан хохирлыг нөхөн төлүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

ДДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

ГОЛ, МӨРНИЙ УРСАЦ БҮРЭЛДЭХ ЭХ, УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН БҮС, ОЙН САН БҮХИЙ ГАЗАРТ АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ, АШИГЛАХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө мөн хуулийн 4.3-т заасан хилийн заагийн дотор олгогдсон тусгай зөвшөөрлийг энэ хууль батлагдсанаас хойш 5 сарын хугацаанд цуцална.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2, 17.3.3 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.5.3 дахь заалтын "газар" гэсний өмнө "газар, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон" гэж, мөн зүйлийн 24.4.2 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.2.2 дахь заалтын "авсан," гэсний дараа "ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон," гэж, 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийн "ээмшигчийн" гэсний дараа "болон түүний байгаль орчныг нөхөн сэргээх" гэж, 56 дугаар зүйлийн 56.1.3

дахь заалтын "авч" гэсний дараа ", эсхүл тухайн талбайд ашигт малтмал хайх, ашиглахыг хуулиар хориглож" гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр

Дугаар 54

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай" Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 43 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Төрийн захиргааны байгууллагын

тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийн "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг" гэсэн хэсэгт Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд "16". Мэргэжлийн боловсрол, сургалтын газар" гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24

дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий



газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараахь арга хэмжээг энэ тогтоол батлагдсанаас хойш 3 сарын хугацаанд авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай:

1/ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын геологи, уул уурхай, газрын кадастрын бүртгэл, мэдээллийг шинэчлэн гаргасны үндсэн дээр эдгээр газрын хилийн заагийг тогтоож, олон нийтэд мэдээлэх;

2/ гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан

бүхий газрын хилийн заагийн дотор үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд ашигт малтмалын тухай болон байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Б.Батбаяр/, болон Эдийн засгийн байнгын хороо /Ц.Баярсайхан/-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр

Дугаар 56

Улаанбаатар хот

Улсын Их Хурлын 2009 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2009 оны намрын ээлжит чуулганаар дараахь асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй:

1/ Монгол Улсын 2010 оны төсвийн тухай хуулийн төсөл;

2/ Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2010 оны төсвийн тухай хуулийн төсөл;

3/Нийгмийн даатгалын сангийн 2010 оны төсвийн тухай хуулийн төсөл;

4/Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн төсөл;

5/Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн төсөл;

6/Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн төсөл;

7/Хадгаламжийн даатгалын тухай хуулийн төсөл;

8/Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн төсөл;

9/Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл;

10/Мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хуулийн төсөл;

11/Өрсөлдөөний тухай хуулийн төсөл;

12/Концессийн тухай хуулийн төсөл;

13/Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай болон Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төслүүд /шинэчилсэн найруулга/;

14/Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

15/Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч мэргэжилтэн авах тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

16/Цагдаагийн байгууллагын тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

17/Шүүхийн шинжилгээний тухай хуулийн төсөл;

18/Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын заавал даатгах даатгалын тухай хуулийн төсөл;

19/Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

20/Инновацийн тухай хуулийн төсөл;

21/Иргэний нисэхийн тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

22/Нислэг, техникийн осол, зөрчлийг шинэчлэн судлах тухай хуулийн төсөл;

23/Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

24/Бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн төсөл;

25/Бэлчээрийн тухай хуулийн төсөл;

26/Агаарын тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

27/Агаарын төлбөрийн тухай хуулийн төсөл;

28/Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

29/Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

30/Хүнсний тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;



31/Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;
 32/Бичил уурхайн хуулийн төсөл;
 33/Эрүүл мэндийн тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;
 34/Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;
 35/Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;
 36/Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;
 37/Төрийн нууцын тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;
 38/Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;
 39/Хэвлэлийн байгууллагуудын тухай хуулийн төсөл;
 40/Төмөр замын тээвэрлэлтийн тухай хуулийн төсөл;
 41/Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн төсөл;
 42/Иргэдийн мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн төсөл;
 43/ Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн төсөл;
 44/ Нийгмийн халамжийн багц хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;
 45/ Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;
 46/Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн төсөл;
 47/Чөлөөт бүсийн тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;
 48/Уламжлалт мэдлэгийн тухай хуулийн төсөл;
 49/Барааны тэмдгийн тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;
 50/Итгэмжлэлийн тухай хуулийн төсөл;
 51/Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;
 52/Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай* Улсын Их Хурлын тогтоолын төсөл;
 53/Төрөөс мөнгөний бодлогын талаар 2010 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай* Улсын Их Хурлын тогтоолын төсөл;
 54/Эрдэс баялгийн салбарыг 2015 он хүртэл хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай* Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

55/Төрийн өмчийг 2009-2012 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай* Улсын Их Хурлын тогтоолын төсөл;
 56/Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай* Улсын Их Хурлын тогтоолын төсөл;
 57/Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн дунд хугацааны стратеги батлах тухай* Улсын Их Хурлын тогтоолын төсөл;
 58/Ус хөтөлбөр батлах тухай* Улсын Их Хурлын тогтоолын төсөл;
 59/Монгол Улсын төмөр замын сүлжээг өргөжүүлэх хөтөлбөр батлах тухай* Улсын Их Хурлын тогтоолын төсөл;
 60/Гадаад харилцааны эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх хөтөлбөр батлах тухай* Улсын Их Хурлын тогтоолын төсөл;
 61/Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр батлах тухай* Улсын Их Хурлын тогтоолын төсөл;
 62/Газрын тосны салбарт төрөөс баримтлах бодлого батлах тухай* Улсын Их Хурлын тогтоолын төсөл;
 63/Биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай* Улсын Их Хурлын тогтоолын төсөл;
 64/Монгол Улсын төрийн цэргийн бодлогын үндэсний шинэчлэн батлах тухай* Улсын Их Хурлын тогтоолын төсөл;
 65/Бусад.

2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, мөн энэ тогтоолын 1 дэх заалтад зааснаас бусад хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг 2009 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх асуудлыг тухайн үед нь шийдвэрлэж байхаар тогтоосугай.

3.Улсын Их Хурлын 2009 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр энэ тогтоолд дурдаагүй хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хууль санаачлагчаас өргөн мэдүүлбэл энэ оны намрын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд оруулахыг Улсын Их Хурлын даргад зөвшөөрсүгэй.

4.Улсын Их Хурлын 2009 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Засгийн газар /С.Баяр/, Байнгын хороодын дарга, Улсын Их Хурал дахь намын бүлгийн ахлагч нар болон Тамгын газар /Ц.Шаравдорж/-т тус тус даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр

Дугаар 57

Улаанбаатар хот

Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай

Ашигт малтмалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт, 29 дүгээр зүйлийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Оюу толгой ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьцааны төрийн эзэмшлийн доод хэмжээг 34 хувиар тогтоосугай.

2. Оюу толгой ордыг ашиглахтай холбогдуулан хөрөнгө оруулалтын гэрээг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид нийцүүлэн Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 40 дүгээр тогтоолоор баталсан үндсэн зарчим, удирдамж, Эдийн засгийн байнгын хорооны 2009 оны 05 дугаар сарын 08-ны

өдрийн санал, дүгнэлтийг харгалзан байгуулахыг Засгийн газар /С.Баяр/-т зөвшөөрсүгэй.

3. Эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар анхны хөрөнгө оруулалтыг нөхсөний дараа төрийн эзэмшлийн хувьцааны хэмжээг 50-иас доошгүй хувьд хүргэж нэмэгдүүлэх асуудлыг хөрөнгө оруулагчтай тохиролцон шийдвэрлэхийг Засгийн газар /С.Баяр/-т үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Баярсайхан/-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр

Дугаар 58

Улаанбаатар хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай" Улсын Их Хурлын тогтоол баталсантай холбогдуулан Засгийн газраас 2009 оны 3 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Оюу толгой ордыг ашиглах

хөрөнгө оруулалтын гэрээний тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 07 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 59

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 24 дүгээр тойрогт нөхөн сонгууль товлон зарлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 24 дүгээр тойрогт явуулах нөхөн сонгуулийг 2009 оны 9 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэхээр товлон зарласугай.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 24 дүгээр тойрогт явуулах нөхөн сонгуулийн санал хураалтыг 2009 оны 10 дугаар сарын 18-ны ням гаригт явуулахаар тогтоосугай.

3. Энэ тогтоолыг 2009 оны 7 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 07 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 60

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 24 дүгээр тойрогт явуулах нөхөн сонгуулийн зардлын хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг 146,015,963 төгрөгөөр тогтоосугай.

2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай.

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 24 дүгээр тойрогт явуулах нөхөн сонгуулийн улсын

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 07 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 61

Улаанбаатар хот

Монгол Улсын Ерөнхийлөгчийн алба хашиж байсан Н.Энхбаярын хангамжийн тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн алба хашиж байсан Намбарын Энхбаярын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай:

1/улсын төсвийн зардлаар 100 хавтгай дөрвөлжин метр ашигтай талбай бүхий өвлийн орон сууцны зураг төсөл хийж, барьж ашиглалтад оруулан Намбарын Энхбаярын өмчлөлд шилжүүлэн өгөх;

2/бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон өдрөөс эхлэн шадар туслах, үйлчлэгч, тогооч, жолооч тус бүр нэгийг 4 жилийн хугацаанд ажиллуулж, зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх;

3/бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон өдрөөс эхлэн түүний амьдрах орон сууцны барьж ашиглалтад оруулах хүртэлх хугацаанд 100 хавтгай дөрвөлжин метр ашигтай талбай бүхий орон сууцаар хангаж, цахилгаан, дулаан, усны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 03 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 76

Улаанбаатар хот

Зарим албан тушаалын цалингийн жишгийг тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн жишгийг дор дурдсанаар тогтоож 2009 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй:

-Нийслэлийн Засаг даргын орлогч

442170-494230

-Аймгийн Засаг даргын орлогч

424230-460270

-Дүүргийн Засаг даргын орлогч

320320-410296

-Сумын Засаг даргын орлогч

290250-380314

чиглэл баримталж ажиллахыг төсвийн ерөнхий менежер нарт даалгасугай.

3. "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 354 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл"-ийн "ТЗ-13" гэсэн хэсгийн "нийслэлийн Засаг даргын орлогч" гэснийг, "ТЗ-12" гэсэн хэсгийн "аймгийн Засаг даргын орлогч" гэснийг, "ТЗ-9" гэсэн хэсгийн "дүүргийн Засаг даргын орлогч" гэснийг, "ТЗ-8" гэсэн хэсгийн "сумын Засаг даргын орлогч" гэснийг тус тус хассугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД

Т.ГАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 03 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 77

Улаанбаатар хот

Зарим агентлагийн байршлыг тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороог Засгийн газрын II байрны "А" корпуст, Цөмийн энергийн газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Мал эмнэлэг, үржлийн газрыг Засгийн газрын XI байранд, Ойн газрыг Засгийн газрын III байранд, Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрыг Засгийн газрын XII байр болон хуучнаар Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн үйлчилгээний төвийн байранд, Улсын бүртгэлийн ерөнхий газрыг хуучнаар Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв болон Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар,

"Монгол тамга" төрийн өмчит үйлдвэрийн газрын байранд тус тус байрлуулсугай.

2. Дээрх агентлагуудын байр ашиглалттай холбоотой урсгал зардлыг тус бүрийн төсөвт нь тусгах, Засгийн газрын XI байрны засварт шаардагдах зардлын тооцоог хянаж санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогтод зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Б.ДОЛГОР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 03 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 78

Улаанбаатар хот

Нэрэмжит болгох тухай

Түүхэн үйл явдлыг тэмдэглэх, төр, нийгмийн зүтгэлтэн, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь хүндэтгэх ажлыг зохион байгуулах журам, холбогдох байгууллагын саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Зэвсэгт хүчний 013 дугаар ангийг хошууч генерал Рашмаагийн Гаваагийн.

2. Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийг хошууч

генерал Гүрийн Рагчаагийн нэрэмжит тус тус болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Ё.ОТГОНБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2009 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 37

Улаанбаатар хот

Улсын үзлэг явуулах тухай

1. Архивын тухай хуулийн 9.2.3-ыг үндэслэн архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийг 2009 оны 9, 10 дугаар сард багтаан явуулсугай.

2. Улсын үзлэгийг удирдан зохион байгуулах төв комиссын бүрэлдэхүүнийг 1 дүгээр, улсын үзлэг явуулахад баримтлах удирдамжийг 2 дугаар хавсралт есоор тус тус баталсугай.

3. Улсын үзлэгийг тогтоосон хугацаанд явуулж, дүнг нэгтгэн цаашид авах арга хэмжээний

талаархи саналын хамт 2009 оны 11 дүгээр сарын 30-ны дотор Засгийн газарт танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид даалгасугай.

4. Улсын үзлэг явуулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг 2009 оны төсвийн багцдаа багтаан санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР



Ерөнхий сайдын 2009 оны 37 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН УЛСЫН ҮЗЛЭГИЙГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨВ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга - Хууль зүй, дотоод хэргийн сайд
Орлогч дарга: - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга;

-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга /тохиролцсоноор/
-Архивын ерөнхий газрын дарга.

Гишүүд: - Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;

- Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга;

- Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга;

- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;

- Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга;

- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

- Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга;

- Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

- Мэдээлэл, шуудан, харилцаа, хол-боо, технологийн газрын дарга;

- Нийслэлийн Засаг даргын орлогч /нийгмийн асуудал хариуцсан/;

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хуулийн хэлтсийн дарга.

Нарийн бичгийн дарга - Архивын ерөнхий газрын Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын хэлтсийн дарга

Ерөнхий сайдын 2009 оны 37 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН УЛСЫН ҮЗЛЭГИЙН УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг (цаашид "үзлэг" гэх)-ийн зорилго нь архивын хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах, төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалт, төлөвлөлт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны түвшинг тогтоож, дүгнэлт хийх, түүний үндсэн дээр цаашид авах арга хэмжээний зорилт, чиглэлийг тодорхойлоход оршино.

1.2. Үзлэгийг батлагдсан удирдамж, аргачлалын дагуу 2009 оны 9, 10 дугаар сард улсын хэмжээнд зохион явуулна.

1.3. Үзлэгийг зохион явуулахдаа Архивын тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, Төрийн албан ёсны хэлний тухай хууль, Байгууллагын нууцын тухай

хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад акт, энэхүү удирдамжийг мөрдлөг болгоно.

Хоёр. Үзлэгийн зохион байгуулалт

2.1. Үзлэгийг төв, салбар, байгууллагын комисс зохион явуулна.

2.2. Төв комисс дараахь үүрэг гүйцэтгэнэ:

2.2.1. Үзлэгт бэлтгэх, үзлэгийг улсын хэмжээнд зохион явуулах;

2.2.2. архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтыг шалгаж, дүгнэх үзүүлэлт, аргачлалыг хянан баталж, үзлэгт бэлтгэх арга хэмжээний хүрээнд бүсчилсэн сургалт, семинар зохион байгуулах;

2.2.3. үзлэгт хамрагдах байгууллагын жагсаалт, үзлэгийн нэгдсэн төлөвлөгөө, хуваарь гаргах;

2.2.4. төв болон салбар комиссын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

2.2.5. салбар комиссын үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжил арга зүйн дэмжлэг, тусалцаа үзүүлэх, заавар, чиглэл өгөх;

2.2.6. Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллага, яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт үзлэг явуулах, дүгнэх;

2.2.7. үзлэгийн нэгдсэн дүнг гаргах, цаашид авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт боловсруулж, холбогдох шийдвэрийн төслийн хамт Засгийн газарт танилцуулах.

2.3. Салбар комиссыг Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллага, яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тухайн байгууллагын удирдлагын шийдвэрээр 2009 оны 5 дугаар сарын 15-ны дотор байгуулна.

Салбар комисс нь дараахь үүрэг гүйцэтгэнэ:

2.3.1. төв комиссоос өгсөн заавар,

чиглэлийн дагуу салбарын хэмжээнд үзлэгт хамрагдах байгууллагын жагсаалт болон үзлэг явуулах хуваарь, үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөө гаргаж харьяа байгууллагад хүргүүлэх, биелэлтийг хангуулах;

2.3.2. байгууллагын комиссын үйл ажиллагаанд хяналт тавих, зохион байгуулалт, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;

2.3.3. салбар, орон нутгийн хэмжээнд үзлэг явуулж тайлан мэдээг нэгтгэн дүгнэж, үзлэгийн мөрөөр цаашид авах арга хэмжээний талаар тодорхой санал боловсруулан Төв комисст хүргүүлэх.

2.4. Байгууллагын комиссыг тухайн байгууллагын удирдлагын шийдвэрээр байгуулна. Комисс нь дараахь үүргийг гүйцэтгэнэ:

2.4.1. үзлэгт бэлтгэх ажлыг байгууллагын хэмжээнд зохион байгуулах;

2.4.2. үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөө гаргаж, биелэлтийг хангах;

2.4.3. зохион байгуулалтын нэгж, ажилтнуудыг үзлэгт бэлтгүүлэх;

2.4.4. тухайн байгууллага дээр төв болон салбар комиссоос үзлэг хийхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг уялдуулах.

2.5. Үзлэгийг төв, салбар комиссын гишүүд, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын байцаагч, төрийн архивын болон байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудын оролцоотойгоор явуулна.

Гурав. Үзлэгийн чиглэл, үндсэн үзүүлэлт

3.1. Үзлэгийг дараахь чиглэлээр зохион явуулна:

3.1.1. байгууллагын архивын үйл ажиллагаа;

3.1.2. албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа;

3.1.3. "Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилт;

3.1.4. төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт.

3.2. Байгууллагын архивын ажлыг дараахь үндсэн үзүүлэлтийн дагуу шалгаж, дүгнэнэ:

3.2.1. байгууллагын удирдлагаас архивын ажлыг сайжруулах талаар авсан зохион байгуулалтын арга хэмжээ, үр дүн;

3.2.2. байгууллагын архивын нөхөн бүрдүүлэлт, архивт баримт хүлээн авах журам, түүний хэрэгжилт;

3.2.3. архивын баримтыг эмхлэн цэгцэлж, данс бүртгэл хөтөлсөн байдал;

3.2.4. баримт бичиг нягтлан шалгах комиссын үйл ажиллагаа, үр дүн;

3.2.5. архивын баримтын тоо бүртгэл;

3.2.6. архивын эрдэм шинжилгээний лавлах зохиож, хөтөлсөн байдал;

3.2.7. хүний нөөцийн холбогдолтой баримтын эмх цэгц, хадгалалт, хамгаалалт;

3.2.8. архивын сан хөмрөгийн баримтын эмх цэгц, хадгалалт, хамгаалалт, ашиглалт, үйлчилгээ;

3.2.9. төрийн архивт баримт шилжүүлэх журам, түүний хэрэгжилт.

3.3. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг дараахь үндсэн үзүүлэлтийн дагуу шалгаж, дүгнэнэ:

3.3.1. байгууллагын удирдлагаас албан хэрэг хөтлөлтийн ажлыг сайжруулах талаар авсан зохион байгуулалтын арга хэмжээ, үр дүн;

3.3.2. албан хэрэг хөтлөлтийн талаар ажилтнуудын эрх үүрэг, хариуцлагыг журамлан тогтоосон байдал, түүний хэрэгжилт;

3.3.3. байгууллагын үйл ажиллагаа, бичиг хэргийн ажлын автоматжуулалт болон ажлын байрыг техник хэрэгслээр хангасан байдал;

3.3.4. удирдлагын үйл ажиллагааг баримтжуулж, албан баримт бичгийг стандартын дагуу зохиож бүрдүүлсэн байдал;



3.3.5. бичиг хэргийн бүртгэл, мэдээлэл, лавлагааны ажлын зохион байгуулалт, дээд байгууллагаас ирсэн баримт бичиг, иргэдийн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэж байгаа байдал;

3.3.6. хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж, үйл ажиллагаандаа хөтөлж хэвшсэн байдал;

3.3.7. удирдлагын баримтыг ангилж төрөлжүүлсэн, албан хэрэг хөтөлж бүрдүүлсэн байдал;

3.3.8. мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах талаар авсан арга хэмжээ, үр дүн;

3.3.9. тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудасны хадгалалт, хамгаалалт, ашиглалт;

3.3.10. Төрийн албан ёсны хэлний тухай, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжүүлж байгаа байдал.

3.4. Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр-ийн хэрэгжилтийг дараахь үндсэн үзүүлэлтийн дагуу шалгаж, дүгнэнэ:

3.4.1. архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн;

3.4.2. архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэд бүтэц бүрдсэн байдал;

3.4.3. архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрэж байгаа байдал.

3.5. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтыг дараахь үндсэн үзүүлэлтийн дагуу шалгаж, дүгнэнэ:

3.5.1. байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, ирээдүйн дүр төрхийг тодорхойлсон байдал;

3.5.2. байгууллагын өөрчлөлт шинэтгэл, хөгжлийн түвшин нь тухайн байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэх чадвархийг бүрдүүлэх шаардлагыг хангаж байгаа байдал;

3.5.3. байгууллагын хүний нөөцийн түвшин нь тухайн байгууллагын үйл ажиллагааны

зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, ирээдүйн дүр төрхөд хүрэх стратегийг хэрэгжүүлэх шаардлагыг хангаж байгаа байдал;

3.5.4. байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн.

Дөрөв. Үзлэгийн дүн гаргах

4.1. Үзлэгийг энэхүү удирдамжийн 3.2, 3.3, 3.4, 3.5-д заасан үндсэн үзүүлэлтийн дагуу шалгаж, Төв комиссоос гаргасан аргачлалын дагуу үндсэн үзүүлэлт бүрт 0-100 хүртэл оноо өгч, дундаж дүнг гаргана. Ингэхдээ 90-100 оноонд "А" буюу "Маш сайн"; 80-89 оноонд "В" буюу "Сайн"; 70-79 оноонд "С" буюу "Хангалттай"; 60-69 оноонд "D" буюу "Дутагдалтай"; 0-59 оноонд "E" буюу "Хангалтгүй" гэсэн үнэлгээ өгнө.

4.2. Үзүүлэлт бүрт оноо өгөхдөө ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүн, чанар зэргийг харгалзан дүгнэнэ.

4.3. Салбар комисс нь Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллага, яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын харьяа байгууллагуудын хэмжээнд явуулсан үзлэгийн дүнг нэгтгэн, тайлан мэдээ болон үзлэгийн мөрөөр цаашид авах арга хэмжээний талаархи саналын хамт 2009 оны 10 дугаар сарын 30-ны дотор Төв комисст ирүүлнэ.

4.4. Төв комисс нь үзлэгийн дүнг улсын хэмжээнд нэгтгэн гаргана.

4.5. Төв комисс нь үзлэгийн дүнгээр байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын түвшинг тогтоож улс, салбар, орон нутгийн хэмжээнд шалгаруулан байр эзлүүлэх ажлыг зохион байгуулна.

4.6. үзлэгт хангалтгүй дүн үзүүлсэн байгууллага, албан тушаалтанд Архивын тухай, Захиргааны хариуцлагын тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

4.7. Төв, салбар, байгууллагын комисс нь үзлэгийн холбогдолтой баримтуудыг эмхлэн цэгцэлж, хадгаламжийн нэгж бүрдүүлэн байгууллагын болон төрийн архивт шилжүүлнэ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргах.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн редакци.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэлэлцэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон-128 тоот

☎ 262420, 329612
Индекс 14003

☎ 329487

Хэвлэлийн хуудас 4